

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

2014 он

“ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ” БОДЛОГЫН СУДАЛГАА

АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	3
УДИРТГАЛ	3
НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА , ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	5
1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ойлголт, эрх зүйн зохицуулалт	5
1.2. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын гүйцэтгэл: эрх зүйн зохицуулалт, тогтоол гүйцэтгэх ажиллагааны биелэлт, тулгамдаж буй асуудал	13
1.3. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл: шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт, тулгамдаж буй асуудал	24
1.4. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл: эрх зүйн зохицуулалт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт, тулгамдаж буй асуудал.....	36
ХОЁР. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА	42
2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс:.....	42
2.2. Бүгд Найрамдах Солонгос Улс	43
ДҮГНЭЛТ.....	47
Санал зөвлөмж.....	50
НОМ ЗҮЙ.....	52
ХАВСРАЛТ.....	54

ХУРААНГУЙ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс “Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт” сэдэвт бодлогын судалгааны ажлыг 2014 оны 4 дүгээр улиралд Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаачид хийж гүйцэтгэлээ.

Судалгааг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, эрх зүйн зохицуулалт; Олон улсын сайн туршлага гэсэн хоёр бүлэгт ангиллаа. Судалгааны нэгдүгээр бүлэгт Шийдвэр гүйцэтгэх газраас Улсын хэмжээнд жил бүр гаргадаг статистик мэдээнд тулгуурлан 2011, 2012, 2013 оны хорихоос өөр төрлийн ял оноосон шүүхийн тогтоол, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх баримт бичгийн биелэлтийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийн, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нийт 66 ажилтнаас авсан санал асуулгын тайлан, хүүхдийн тэтгэлгийн төлбөр барагдуулалтын мэдээ, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд 2014 оны III улиралд иргэд, байгууллагаас ирсэн нийт өргөдөл гомдлын тайлан зэргийг судалж дүн шинжилгээ хийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч буй бэрхшээл, хууль эрх зүйн орчны нийцтэй байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шүүхийн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан, нөхцөлийг илрүүлэн цаашид авч хэрэгжүүлэх боломжит санал, зөвлөмжийг боловсруулав. Судалгааны хоёрдугаар бүлэгт Бүгд Найрамдах Солонгос Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын сайн туршлагыг судалж харьцуулалт хийн дотоодод хэрэгжүүлж болхуйц хувилбарыг санал болголоо.

Шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж буй хэдий ч улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт хангалтгүй байна.

***Энэхүү судалгааны явцад эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд хамруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34, 40, 133, 143 дугаар зүйл, Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1 дэх хэсэг, 177.4 дэх хэсэг, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дах хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлд Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд судалгаанд хавсаргасан болно.*

УДИРТГАЛ

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнийг хангахуйц хууль эрх зүйн орчин, баталгааг бүрдүүлэх эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхийн тулд 1998 онд УИХ-аас Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг баталж энэ хүрээнд олон хууль тогтоомжид өөрчлөлт орж шинээр чухал ач холбогдол бүхий эрх зүйн актууд батлагдсаны нэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль юм. Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсэн хэн боловч шүүхэд гомдол, нэхэмжлэл гарган зөрчигдсэн эрхээ сэргээлгэн шийдвэр, магадлал, тогтоол гаргуулдаг. Энэхүү гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг сайн дурын үндсэн дээр биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа хийгддэг бөгөөд ИХШХШТХ-ийн 18 дугаар бүлэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэлийн албадах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тодорхойлсон. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

ажиллагаа шуурхай, үр нөлөөтэй хэрэгжсэнээр Үндсэн хуулиар баталгаажсан энэхүү эрх бүрэн хангагдана.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн төлбөр төлөгчийн төлбөрийн чадвараас шууд шалтгаалдаг бөгөөд нэхэмжлэгчээс эд хөрөнгийг шүүхийн шатанд хамгаалуулах арга хэмжээг авхуулаагүйгээс төлбөр төлөгч эд хөрөнгөө нуух, бусдад шилжүүлж үрэгдүүлсэнээс төлбөрт гаргуулах эд хөрөнгө тогтоогдохгүй байх, төлбөрөөс зайлсхийдэг, салбар хуулиуд, хуулийн бусад байгууллагын хамтын ажиллагаа уялдаа холбоо хангалтгүй, захиргааны байгууллага албан тушаалтан шүүхийн шийдвэр биелүүлдэггүй, биелүүлэхээс зайлсхийдэг зэрэг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах томоохон шалтгаан болж байна. Мөн энэ чиг үүргийг гүйцэтгэж буй шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал тэдний ажиллах орчин, нийгэм эдийн засгийн баталгаа хангалтгүй байна. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь өмнө дагаж мөрдөж байсан хуулиудаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааг илүү нарийвчилсан хэдий ч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практикт хэрэглэхэд ялангуяа, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал урамшуулал, хүүхдийн тэтгэлгийн төлбөр гаргуулах, үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагаанд бэрхшээл тулгарч байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

Судалгааны зорилго: Хорихоос өөр төрлийн ял оноосон шүүхийн шийтгэх тогтоол, иргэн, захиргааны хэргийн талаар гарсан анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын хэрэгжилтийг статистик мэдээнд тулгуурлан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч буй бэрхшээл, тулгамдсан асуудлын шалтгаан, үндэслэлийг илрүүлэн цаашид шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг нэг мөр хангах арга замыг тодорхойлж бусад улсын сайн туршлагыг судалсны үндсэн дээр санал, зөвлөмж дэвшүүлэхэд оршино.

Судалгааны ажлыг дараах зорилтын хүрээнд гүйцэтгэлээ.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ойлголт, эрх зүйн зохицуулалт, түүхэн уламжлалыг судлах
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг олж тогтоох,
3. Улсын хэмжээнд 2011, 2012, 2013 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн баримт бичгийн статистик тоон мэдээ, бүртгэлд үндэслэн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн бодит биелэлтийг судалж дүн шинжилгээ хийх
4. Бусад улсын /БНСУ, ХБНГУ/ шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практик, эрх зүйн зохицуулалтыг судалж дотоодын практиктай харьцуулах
5. Судалгааны явцад цугларсан тоон мэдээ, судалгааны бусад материалыг нэгтгэн цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хэрэгжилтийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаж сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Судлагдсан байдал: 2002 оноос өмнө буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан гарахаас өмнө шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбогдолтой судалгаа шинжилгээний ажил цөөн байгаа боловч сүүлийн 10 жилд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь эрчимтэй судлагдаж, анхаарал татаж буй асуудлуудын нэг болж байна. Сүүлийн 10 жилд хэвлэгдэн гарсан ном, сэтгүүл, илтгэл зэргийг дурдвал:

Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор, профессор, хурандаа А.Лхагва “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” /2004 он/ , /2008 он/ , Ц.Дашзэвэг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” /2006 он/, В.Шаллер “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” /2005 он/, 2007 он/ , Ш.Эрдэнэбат , О.Алтангэрэл нарын “Шийдвэр гүйцэтгэгчийн ном” /2004 он/ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл” улирал тутмын эрдэм шинжилгээний сэтгүүл /2012 он/, “Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” сэдэвт хуулийн байгууллагуудын нэгдсэн хэлэлцүүлгийн эмхтгэл /2014 он/, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны цахим хуудас <http://www.courtservice.mn/contentlist/category303.shtml> , Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн нэгдсэн зөвлөгөөн дээр тавьсан илтгэл зэрэг болно.

Судалгааны арга зүй: Энэхүү судалгаанд шинжлэх ухааны үндсэн арга болох **баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга , задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх** аргыг хэрэглэснээс гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практикийг судлахдаа санал асуулга болон ярилцлагын аргуудыг ашигласан болно.

НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА , ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ойлголт, эрх зүйн зохицуулалт

Хүний эрхийн Түгээмэл тунхаглал: “... эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээлгэн тогтоолгох эрхэй”¹

1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор 1998 онд УИХ-аас Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэнээр Үндсэн хуульд тусгалаа олсон хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн баталгааг төр бүрдүүлж, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрх ашгийг нь хамгаалах чиглэлээр олон хууль тогтоомжид өөрчлөлт орж, шинээр эрх зүйн актууд батлагдан гаргасны нэг нь 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль юм. Энэ хуулийн хүрээнд шүүх болон бусад байгууллагаас гарсан шийдвэр, эрх зүйн баримт бичгийн үндсэн дээр бусдын хуулиар хамгаалагдсан зөрчигдсэн эрх ашгийг сэргээж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахтай холбогдсон нийгмийн тодорхой харилцаа зохицуулагдаж байна.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар, иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлээд шүүхээс гаргасан шийдвэр, шүүхээр баталгаажуулсан нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, захиргааны шийтгэвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан болон эд хөрөнгө, зардал гаргуулах, хохирол төлүүлэх заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг төрөөс эрх олгогдсон байгууллага, төлбөр авагч, төлбөр төлөгч бусад субъектүүдийн оролцоотойгоор гүйцэтгэх ажиллагааг зохицуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсэн хэн боловч шүүхэд гомдол, нэхэмжлэл гарган зөрчигдсэн эрхээ сэргээлгэн

¹ Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйл.1948.12.10

шийдвэр, магадлал, тогтоол гаргуулдаг. Энэхүү гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг сайн дурын үндсэн дээр биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа хийгддэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл нь эрүүгийн хэргийн талаар гарсан хорихоос өөр төрлийн ялын шүүхийн шийтгэх тогтоол, иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна. Шүүхийн шийдвэр гэдэгт эрх зүйн маргаан, захиргааны хэрэг болон эрүүгийн хэргийн хохирол төлбөрийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр, шийтгэх буюу цагаатгах тогтоол, мөн давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол зэрэг болно. Түүнчлэн, Олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын арбитрын байгууллагын шийдвэр, шүүхээр баталгаажуулсан нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, захиргааны шийтгэвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан болон хөрөнгө гаргуулах заалт, үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар эрх шилжүүлсэн тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хамруулан авч үздэг.

ИХШШТХ-ийн 183 дугаар зүйлд: Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт, тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал:

Монгол оронд 1921 онд Ардын хувьсгал ялж, Ардын Намын төв хороо, түр Засгийн газрын хамтарсан хурал 1921 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Нийслэл хүрээнд болж Засгийн газрын яамдыг шинээр байгуулахад дотоод, гадаад ерөнхий гурван хэлтэстэйгээр Шүүх яамыг байгуулсан байна. Эдүгээгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага анх 1921 оны 7 дугаар сарын 10-нд үүссэн гэж үзэх түүхэн болон эрх зүйн бүрэн үндэслэлтэй.²

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь 1994 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай, 1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай, 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан гарахаас өмнө 1949 оны Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль, 1967 оны Иргэний байцаан шийтгэх тухай хууль, 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудаар зохицуулагдаж байсан байна.

Монгол Улсын Их Хурал 1993 оны 12 дугаар сард Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хууль, 1994 онд Шүүхийн шийдвэр

² Лхагваа.А (2012)№1 Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл сэтгүүл,11

гүйцэтгэлийн албаны тухай, 1996 онд Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай, 2002 оны 9 дүгээр сард Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлан гаргаснаар одоогийн хорих болон шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын тогтолцоо, эрх үүрэг нэлээд өөрчлөгдөж хуульчлагдсан.

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдөр 299 дүгээр тогтоол гаргаж, Улсын Дээд Шүүхийн тамгын газрын шийдвэр гүйцэтгэлийн хянан байцаах хэлтсийг Хорих байгууллагуудыг удирдах газарт нэгтгэн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болгож өргөтгөн зохион байгуулжээ.

Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газарт Шийдвэр гүйцэтгэлийн газар, Хорих ял эдлүүлэх газрыг тус тус харьяалуулан байгуулсан ба Монгол Улсын хууль зүй дотоод хэргийн сайдын 2000 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн “Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын бүтэц, орон тоог батлах тухай” 44 дүгээр тушаалаар хоёр хэлтсийг өргөтгөн Захиргааны удирдлагын газар, Үйлдвэр, санхүү хангалтын газар болгохоор шийдвэрлэжээ.

Одоогийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь бүтцийн хувьд, Тогтоол гүйцэтгэх газар, Шийдвэр гүйцэтгэх газар, Захиргааны удирдлагын газар, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар гэсэн таван газар, Улсын хэмжээнд нийт 211 шийдвэр гүйцэтгэгчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Улсын хэмжээнд эрх олгогдсон нийт 211 шийдвэр гүйцэтгэгч байгаагаас нийслэлд 93, орон нутагт 118 шийдвэр гүйцэтгэгч болон 39 ахлах шийдвэр гүйцэтгэгчийн орон тоотойгоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тойргийн журмаар зохион байгуулан явуулж байгаа, нийт алба хаагчдийн 70 орчим хувийг эмэгтэй албан хаагч эзэлж байна.

Өнөөдрийн байдлаар нэг шийдвэр гүйцэтгэгчид дундажаар нийслэлд 161, орон нутагт 135 гүйцэтгэх баримт бичиг ногдож байгаа ч зарим тойргийн харьяаллаас шалтгаалан ажлын ачаалал харилцан адилгүй, ялгамжтай тогтоогддог.

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиар Шийдвэр гүйцэтгэх газар нь Иргэн, Эрүү, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт үндэслэн төлбөр, тэтгэлэг гаргуулах, тодорхой үйл ажиллагааг гүйцэтгүүлэх, гүйцэтгүүлэхгүй байхыг даалгасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.

2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш 12 жилийн хугацаанд иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй 279847 гүйцэтгэх баримт бичиг, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэртэй 61229 гүйцэтгэх баримт бичиг, захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй 5390 гүйцэтгэх баримт бичигт өнгөрсөн хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулан явуулжээ.

Энэ нь нийт гүйцэтгэх баримт бичгийн 80,8 хувь нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр үүнээс 109240 гүйцэтгэх баримт бичиг буюу 31,6 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой, 17,7 хувь нь гэмт хэргийн улмаас учирсан гэм хор, хохирол гаргуулахаар шийдвэрлэсэн шийдвэр, 1,6 хувь нь бусад гүйцэтгэх баримт бичиг эзэлж байгаа юм.

Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 27716 гүйцэтгэх баримт бичиг байгаагийн 72,3 хувь нь иргэнд олгох, 27,7 хувь нь хуулийн этгээд, 3,3 хувь нь банкны байгууллагын нэхэмжлэлтэй төлбөр байгаа ба нийт мөнгөн дүнгийн 75,5 хувь нь өндөр үнийн дүнтэй /100.0 саяас дээш/ гүйцэтгэх бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.

Өнгөрсөн хугацаанд ажил үүргийн шаардлага, цаг үеийн онцлогоос шалтгаалан татан буугдсан арилжааны банк, хадгаламж зээлийн хоршоодод холбогдох төлбөр болон хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий нэгжийг нийслэлд шинээр байгуулан ажилласан байна.³

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.⁴

Иргэн, Захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийн түүхэн уламжлал

Монгол Улсын төр өөрийн орны ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгоход ихээхэн анхаарч ирсний тод илрэл бол 1931-2002 онуудад арван удаа хууль гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулсан явдал юм.

Шүүхийн тогтоол гүйцэтгэх ажиллагаа 1994 оноос өмнө хэд хэдэн хуулийн зохих заалтуудаар зохицуулагдаж байжээ.

- 1926 оны Монгол ард улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль
- 1949 оны Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль
- 1952 оны Иргэний байцаан шийтгэх тухай хууль
- 1957 оны Шүүхийн зохион байгуулах тухай хууль
- 1967 оны Иргэний байцаан шийтгэх тухай хууль
- 1978 оны Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль
- 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- 1994 оны 5-р сараас Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хуулиудын зохих зүйлд иргэний хэргийн талаарх шийдвэрийг хэрхэн биелүүлэх /гүйцэтгэх/ тухай заагдсан байдаг.

Улсын Бага Хурлаас батлан гаргасан “Монгол Ард Улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль”-ийн IX-р бүлгийг Шүүх таслах газруудын тогтоолыг гүйцэтгэх тухай гэж нэрлээд, 11 зүйлийг тусгаж, гүйцэтгэх хуудасны загварыг баталсан байна.

Монгол Улсын 19 дүгээр он буюу 1929 оны 7 дугаар сарын 5-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын XXI хурлын тогтоол, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн мөн оны 64 дүгээр хурлын тогтоолын нэгдүгээр зүйлийг үндэслэн “БНМАУ-ын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль”-д нэмэлт оруулан хуулийн XI

³ Д.Дамдинцэрэн. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал шинэчлэлийн хэрэгцээ, шаардлага. Илтгэл.

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 4 дүгээр зүйл

бүлгийг “Шүүн таслах газруудад өр ширийн зэрэг иргэний хэргийг таслан шийтгэсэн тогтоолыг гүйцэтгэх тухай” гэж нэрлээд 123-301 дүгээр зүйлүүдийг тусгасны дээр тогтоол гүйцэтгэгчээс үйлдэх дансны тэмдэглэл, маягтын загварыг баталжээ.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1949 оны 8 дугаар сарын 6-ны 9 дүгээр зарлигаар батлагдсан Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 6 дугаар бүлгийг “ Шүүхийн гүйцэтгэгч нар” гэж нэрлээд уг хуулийн 42-44 дүгээр зүйлүүдэд дараах заалтууд тусгагдсан байна. Үүнд:

- Иргэний хэргийн талаар гаргасан шийдвэр, магадлалууд ба эд хөрөнгийг гаргуулах асуудалтай холбогдсон эрүүгийн хэргийн шийтгэсэн тогтоолуудыг биелүүлэх ажлыг шүүхийн гүйцэтгэгч нараас гүйцэтгэнэ.
- Шүүхийн гүйцэтгэгч нар бол аймаг, хотын шүүхүүд ба Дээд шүүхийн дэргэд байх бөгөөд шүүх яамнаас эрхлэн томилно. Өөрсдийн ажлын талаар Ардын шүүгч буюу Дээд шүүхийн даргад захирагдана
- Ардын хэсгийн шүүхүүдээс гаргасан эд хөрөнгийг төлүүлэх асуудалтай холбогдсон шүүхийн шийдвэр магадлал ба шийтгэсэн тогтоолуудыг биелүүлэх ажлыг сумдын захиргаанаас гүйцэтгэнэ.
- Шүүхийн гүйцэтгэгч нар ба мөн шүүхийн даалгавраар шүүхийн гүйцэтгэгч нарын үүргийг биелүүлж байгаа сумдын захиргааны ажилтан нараас шүүхийн шийтгэсэн тогтоол, шийдвэр ба магадлалуудыг биелүүлэхээр шаардсан шаардлагыг бүх албан тушаалын хүмүүс ба ард иргэдээс заавал гүйцэтгэвэл зохино гэжээ.

1952 оны БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий байдлыг заахдаа /119 дүгээр зүйлд/:

Шүүхийн гүйцэтгэгч буюу сум дундын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны газруудаас гүйцэтгэх зүйлүүд гэвэл:

- 1) Иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр ба нотариатын конторын гүйцэтгэх хуудсууд
- 2) Торгууль хүлээлгэх ба нэхэмжлэлийг хангах тухай иргэний ба эрүүгийн хэргийн талаар шүүхээс гаргасан магадлалууд, түүнчлэн хулгайлсан ба үрэгдүүлсэн зүйлийг төлүүлэх тухай шийтгэсэн тогтоолууд
- 3) Улсын арбитрын шийдвэрүүд гэжээ.

БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1957 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “ БНМАУ-ын Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 43,44 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах тухай” 123 дугаар зарлиг

БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдээс тогтоох нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүхийн зохион байгуулалтын хуулийн 43,44 дүгээр зүйлийн дор дурдсанаар найруулж өөрчилсүгэй. Үүнд:

43 дугаар зүйл. Ардын хэсгийн шүүхээс эд хөрөнгө төлүүлэх талаар гаргасан шийдвэр магадлал ба шийтгэсэн тогтоолыг биелүүлэх ажлыг ардын хэсгийн шүүхийн нарийн бичгийн дарга нар гүйцэтгэнэ.

44 дүгээр зүйл. Шүүхийн шийтгэсэн тогтоол шийдвэр ба магадлалыг биелүүлэхээр шүүхийн гүйцэтгэгч, ардын хэсгийн шүүхийн нарийн бичгийн дарга нарын

шаардсан шаардлагыг бүх албан тушаалын хүмүүс ба ард иргэд заавал гүйцэтгэвэл зохино гэжээ.

1967 оны БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн “Тогтоол гүйцэтгэлийн ажиллагаа” гэсэн Ү хэсэгт буюу 251-304 дүгээр зүйлээр шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаа зохицуулагдаж байжээ. Энэ хуулийн 252 дугаар зүйлд дор дурдсан шийдвэр, тогтоолуудыг тогтоол гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэж байхаар заасан байна. Үүнд:

- Иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол
- Эрүүгийн хэргийн талаар шүүхээс гаргасан таслан шийдвэрлэх тогтоол, магадлал болон тогтоолын эд хөрөнгө гаргуулах хэсэг
- Захиргааны зөрчил гаргасан этгээдээс эд хөрөнгийн төлбөр гаргуулах талаар шүүгч буюу шүүх, олон нийтийн шүүхээс гаргасан тогтоол
- Шүүхээс баталсан эвлэрсэн хэлэлцээ
- Нотариатын мэдэгдэх хуудас
- Арбитрийн байгууллагын шийдвэр
- БНМАУ-ын Худалдааны танхимын дэргэдэх гадаад худалдааны арбитрийн комиссын шийдвэр
- Олон нийтийн шүүхийн тогтоол
- Иргэдээс маргаангүй төлбөр гаргуулан авах эрх хуулиар олгогдсон захиргааны байгууллагын шийдвэр

Гадаад улсын шүүхээс хуульд заасан тохиолдлын дагуу гаргасан шийдвэр. Энэ зүйлд дурдсан шүүхийн шийдвэр ба бусад байгууллагын тогтоолыг аймаг, хотын шүүхийн тогтоол гүйцэтгэгчид гүйцэтгэнэ.

Харин тогтоол гүйцэтгэлийн ажилд хяналт тавих, тогтоолыг цаг тухайд нь зөв гүйцэтгүүлэх хариуцлагыг шүүгч хүлээнэ гэдгийг хуульчилсан байна.

1978 оны БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн хуулийн 61-63 дугаар зүйлээр Шүүхийн тогтоол гүйцэтгэгчийг томилох, чөлөөлөх журам, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоолыг гүйцэтгэх, шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн шаардлагыг заавал биелүүлэх асуудлууд зохицуулагдаж байсан байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 237 дугаар тогтоолоор “Шүүхийн тогтоол гүйцэтгэх журмын тухай заавар”-ыг батлан гаргажээ.

Энэ зааврын нийтлэг үндэслэлийн “Тогтоол гүйцэтгэх ажиллагааны үндсэн нөхцөл” гэдэгт:

- 1) Аймаг, хотын болон тусгай шүүх, хэсэг, район, орон нутгийн хотын ардын шүүхийн тогтоол гүйцэтгэгчид БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 252 дугаар зүйлд заасан шүүхийн болон бусад байгууллагын шийдвэрийг шүүхийн тогтоол гүйцэтгэлийн журмаар эхлэн гүйцэтгэнэ.
- 2) БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн хуулийн 63 дугаар зүйл, БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 260 дугаар зүйлд зааснаар шүүхийн тогтоол, шийдвэр, магадлалыг биелүүлэхээр шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг бүх албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй.

УИХ-ын 1994 онд батлан гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 191-234 дүгээр зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмыг заажээ. Энэ хуульд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэх шийдвэрүүдэд:

- 1) Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр
- 2) Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн торгох, эд хөрөнгө хураах ял болон хөрөнгө гаргуулах заалт
- 3) Захиргааны зөрчил гаргасан этгээдээс торгууль, төлбөр гаргуулах талаар гарсан шийтгэвэр
- 4) Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар биелүүлбэл зохих гадаад улсын шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр, холбогдох баримт бичиг
- 5) Арбитрийн шийдвэр хамаарагдахаар заасан байна.

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд холбогдох хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар Улсын Дээд Шүүхээс ялангуяа 80-аад онд ихээхэн анхаарч байсан нь дараах тогтоолуудаас харагдана.

- БНМАУ-ын Дээд Шүүхийн бүгд хурлын 1978 оны 12-р сарын 29-ний өдрийн “Шүүхийн шийдвэр, тогтоолын биелэлтэд тавих шүүгчийн хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоол
- БНМАУ-ын Дээд Шүүхийн Тэргүүлэгчдийн 1982 оны 11-р сарын 3-ны өдрийн “Тогтоол гүйцэтгэлийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 9/30 дугаар тогтоол
- Дээд шүүхийн тэргүүлэгчдийн 1982 оны 11-р сарын 3-ны өдрийн “Тогтоол гүйцэтгэлийн ажиллагааг зохион байгуулах, бүртгэх, тооцох, тайлагнах хянах журмын тухай” 9/30 дугаар тогтоол
- Улсын Дээд Шүүхийн Тэргүүлэгчдийн 1983 оны 7-р сарын 28-ны өдрийн “Шүүхийн тогтоол гүйцэтгэчийг ажилд авах, халах журам”-ын тухай 30 дугаар тогтоол
- Улсын Дээд Шүүхийн бүгд хурлын 1983 оны 12-р сарын 27-ны өдрийн “Тогтоол гүйцэтгэлийн ажиллагааг хойшлуулах, хэрэгсэхгүй болгох, албадан биелүүлсний зардал төлүүлэх тухай” 57 дугаар тогтоол
- Улсын Дээд Шүүхийн бүгд хурлын 1983 оны 12-р сарын 27-ны өдрийн “Хүүхдийн тэтгэврийг тогтоон гаргуулж байгаа шүүхийн практикийн тухай” 59 дүгээр тогтоол
- БНМАУ-ын Дээд Шүүхийн дарга, ХБЯ-ны сайдын 1986 оны “Төлбөрт хураагдсан эд хөрөнгийг комиссын хуралдааны журмаар худалдан борлуулах заавар батлах тухай” 262/58 тоот тушаал зэрэг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт:

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэх газар нь иргэн, эрүү, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт үндэслэн төлбөр тэтгэлэг гаргуулах, тодорхой үйл ажиллагааг гүйцэтгүүлэх, гүйцэтгүүлэхгүй байхыг даалгасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.

2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 12 жилийн хугацаанд:

- Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэртэй 61229 гүйцэтгэх баримт бичиг
- Иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй 279847 гүйцэтгэх баримт бичиг
- Захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй 5390 гүйцэтгэх баримт бичигт

шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулан явуулжээ. /График 1/

График 1.



График 2.



Нийт гүйцэтгэх баримт бичгийн 226116 буюу 80,8 хувь нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр, үүнээс 109240 гүйцэтгэх баримт бичиг буюу дунджаар 31,6 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой байна. /График 2/

График 3.



Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийн хувийг сүүлийн гурван жилийн байдлаар авч үзвэл 2011 онд нийт биелүүлбэл зохих 33023 гүйцэтгэх баримт бичгээс 47 хувь буюу 15551 гүйцэтгэх хуудсыг бодитой биелүүлсэн байна. 2012 онд 33031 биелүүлбэл зохих гүйцэтгэх баримт бичгийн 48.3 хувийг бодитой биелүүлсэн бол 2013 онд биелүүлбэл зохих 35187 гүйцэтгэх баримт бичгээс 17721 гүйцэтгэх баримт бичиг буюу 50.8 хувийг бодитойгоор биелүүлсэн байна. /График 3/

Сүүлийн гурван жилийн биелүүлээгүй гүйцэтгэх хуудасны харьцуулалтаас хархад банкны байгууллагын нэхэмжлэл хамгийн их үлдэгдэлтэй буюу 23-27.5 хувийг эзэлж байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж буй хэдий ч улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, бодит биелэлт хангалтгүй байгааг дээрх тоон мэдээ харуулж байна.

1.2. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын гүйцэтгэл: эрх зүйн зохицуулалт, тогтоол гүйцэтгэх ажиллагааны биелэлт, тулгамдаж буй асуудал

Хорихоос өөр төрлийн ял оногдуулах тухай ойлголт: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, хамт олон, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн хор уршгийг ухамсарлуулан ойлгуулж, өөрийн хөдөлмөрөөр нь нийгэм, иргэнд учруулсан хохирлыг барагдуулах зорилгоор хорихоос өөр төрлийн ял оногдуулан хэрэгжүүлдэг байна.

Түүхэн уламжлалыг үзвэл Монголчууд эрт дээр үеэс гэмт хэрэг үйлдсэн хүнийг шоронд хорихоос илүүтэй тэдэнд хийсэн хэргийг нь ойлгуулж, ухамсарлуулахад ялын бодлого чиглэж байсан байна. “Монголын нууц товчоо”, “Их Юань улсын нэвтэрхий хууль” “Монгол-Ойрадын хууль” “Алтан хааны цааз бичиг” “Халх журам хууль” “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” зэрэгт хорихоос өөр төрлийн ял оноох буюу гэмт хэрэгтнийг зөвлөн ухуулах, донгодох, мал амьтдаар торгох, пүнлүү хасах, хөрөнгө хураах, олны өмнө ичээх, дөнгөлөх, занчих, нутаг заан суулгах, аливаа эрхүүдийг бүрмөсөн болон тодорхой хугацаагаар хасах зэргээр шийтгэж ирсэн байна.⁵

2002 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуульд торгох, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах зэрэг хорихоос өөр ялын төрлүүдийг тусган хуульчилсан байдаг. Шүүхийн шийтгэх тогтоолоор хорихоос өөр төрлийн ял оногдуулсан этгээдийн ялын гүйцэтгэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар хэрэгжүүлж байна.

Хорих төрлийн ялын эерэг үр нөлөө харьцангуй бага бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхээс бусад сонгох, сонгогдох эрхийг хасах, гадагш зорчих эрхийг хасах зэрэг нь төдийлөн ач холбогдол багатай юм. Хорих ял эдлүүлэхэд зардал их байх бөгөөд тухайн ялтныг гэмт хэрэг хийснийг илрүүлэхээс эхлэн хорих, хооллох, хувцаслах, байраар хангах зэргээр суллах хүртэлх бүх зардлыг төр хариуцдаг байна. Мөн олон жил хоригдсон ялтнууд суллагдахаараа нийгэмд дасан зохицох чадвар сул, мэргэжил боловсрол, хүрээлэл муутай болдог байна.

⁵ Б.Нямгомбо. “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хуулийг нэг мөр хэрэглэх нь” илтгэл, Улаанбаатар, 2014 он.

Эрүүгийн ялын бодлого чангарснаар шоронгийн хэт дүүргэлтийг бий болгож байгаагаас гадна Монгол улсын шоронгийн нөхцөл нь Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, жишиг дүрмүүдэд заагдсан шаардлагад нийцсэн ял эдлэх орчин бүрдээгүй байна. Энэ нь ялтныг хуульд зааснаар хүмүүжлийн нөлөө үзүүлэх биш харин дахин давтан гэмт хэрэг үйлдэх хань хамсаатантай болгох, гэмт хэрэг үйлдэх талаар харилцан мэдээлэлтэй болох, гэмт хэрэг үйлдэх туршлагатай болох зэрэг сөрөг үзэгдлүүд хорих ял эдэлж байгаа ялтнуудад тохиолдох магадлалтай.

Дэлхийн улс орнуудад аль болох хорихоос өөр төрлийн ялыг оногдуулах, гэмт хэрэгт тохирсон хорихоос өөр төрлийн ялыг оногдуулж, тухайн ялтныг нийгэм, хамт олонд нь байлгаж, учирсан хор хохирлыг арилгуулах, гэмт хэрэг үйлдэхгүй байхыг ухамсарлуулах арга хэмжээ авдаг байна. Ингэхдээ гэмт хэрэгтнийг хянах, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тухайн хэрэгтэнд цахилгаан бугуйвч, суурин болон хөдөлгөөнт телекамер, байрлал тогтоогч “GPS” төхөөрөмж ашиглах зэргээр хяналт тавьдаг байна.

Гадаадын зарим оронд хорихоос өөр төрлийн маш олон янзын төрөл, хэлбэр байна Тухайлбал: Гэрийн хорионд байлгах, эд хөрөнгө хураах, нийтэд тустай ажил хийлгэх, түр хугацаагаар албадан эмчлэх, тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах, цол, одон медаль хураах, нутаг заах, сонгох, сонгогдох эрх хасах, гадагшаа зорчих эрхийг нь хязгаарлах, ан агнах эрхийг хасах, эдийн засгийн эрхийг хязгаарлах гэх мэт маш олон төрлийн ялыг оногдуулж байна.⁶

Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлууд гарсаар байна. Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-д эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан болон эд хөрөнгө, зардал гаргуулах, хохирол төлүүлэх заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас гэж заасан бөгөөд “тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шийтгэх тогтоолд” зарим шүүгч гүйцэтгэх хуудас бичихгүй байгаагаас ялтан хяналтанд бүрэн хамрагдахгүй байна.⁷

Монгол улсын шүүхээс сүүлийн гурван жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн статистик мэдээнээс үзвэл нийт ял шийтгүүлсэн хүмүүсийн 77 орчим хувь нь хорих ял шийтгүүлсэн бөгөөд үлдсэн 23 хувь нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл дөрвөн хүн тутмын гурав нь хорих ял эдэлж байна. Хорих ял эдлүүлэх нь нийгэмд эерэг үр нөлөө багатай бөгөөд эдийн засгийн хувьд зардал ихтэй, Монгол дахь шоронгийн нөхцөл олон улсын шаардлагад нийцээгүй, шоронд удаан хугацаагаар хоригдсоноос нийгэмд дасан зохицох чадвар муу болдог байна. Хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн их байдаггүй тул дэлхий нийтэд хорихоос өөр төрлийн ялын бодлогыг баримтлах хандлагатай байна. Монгол улсад ч хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оногдуулдаг болох эрх зүйн орчин бүрдүүлэх, улмаар оногдуулсан хорих ялыг үр нөлөөтэй хэрэгжүүлдэг болох шинэчлэлийн бодлого явуулах шаардлагатай байна.

⁶ Б.Нямгомбо. “Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага” илтгэл, Улаанбаатар, 2013 он.

⁷ Н.Отгонбаяр. “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зарим асуудал” илтгэл. Улаанбаатар, 2014 он.

Монгол улсад одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулиар торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа хасах ялыг хорихоос өөр төрлийн ялын төрөлд хамааруулж байгаа боловч үүнийг хэрэгжүүлж байгаа арга хэлбэр тодорхой бус нарийвчилсан хуулийн зохицуулалтгүй, иргэний шийдвэр гүйцэтгэлтэй хавсран ялын хэрэгжилтийг хангаж байгаа тул энэ төрлийн ялын ач холбогдол төдийлөн ялгарч харагддаггүй байна. Хорихоос өөр төрлийн ялын эрх зүйн зохицуулалт, ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг төрөл тус бүрээр нь авч үзье.

а. торгох ял:

Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид нийт 225 үйлдлийг гэмт хэрэг хэмээн хуульчилсан бөгөөд түүнийг үндсэн, хүндрүүлэх, онцлон хүндрүүлэх байдлаар задалж үзвэл 449 үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байна. Үүнээс 213 гэмт хэрэгт торгох ялыг оногдуулахаар хуульчилсан байдаг⁸.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар нь дараах дараалал аргачлалын дагуу торгох ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- 1) Ахлах шийдвэр гүйцэтгэгчээс шийдвэр гүйцэтгэгчийн хүлээн авах гүйцэтгэх хуудас, баримт бичиг
- 2) Торгох ялтай ялтныг хүлээн авч, ажиллагаа хийх
- 3) Торгох ялтны гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа хийх
- 4) Албадан биелүүлэх ажиллагаа
- 5) Хэсэгчилэн төлүүлэх
- 6) Торгох ялыг хорих ялаар солих
- 7) Торгох ялаас чөлөөлөх
- 8) Торгох ялыг бодитой биелүүлж, дуусгавар болгох зэрэг ажиллагаа явагддаг байна.

Торгох ял оногдуулсан шийтгэх тогтоолын гүйцэтгэлийн биелэлт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сүүлийн гурван жилийн статистик мэдээнээс үзвэл 2011 онд 307 ялтанд холбогдох 1.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт гүйцэтгэх ажиллагаа явуулж, 232 ялтанд холбогдох 1 тэрбум төгрөгийг бүрэн биелүүлсэн бол 2012 онд 248 ялтанд холбогдох 1.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт гүйцэтгэх ажиллагаа явуулж, 181 ялтанд холбогдох 0.8 тэрбум төгрөгийг бүрэн биелүүлсэн бол 2013 онд 283 ялтанд холбогдох 1.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт гүйцэтгэх ажиллагаа явуулж, 237 ялтанд холбогдох 1.1 тэрбум төгрөгийг бүрэн биелүүлсэн байна⁹.

Гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 2011 онд 75.6 хувь, 2012 онд 73 хувьтай биелсэн бол 2013 онд 83.7 хувь болж өссөн байна. /График 4/

График 4.


⁸ Б.Нямгомбо. “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хуулийг нэг мөр хэрэглэх нь” илтгэл, Улаанбаатар, 2014 он.

⁹ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.



Биелүүлээгүй үлдэгдэл гүйцэтгэх хуудас 2011 онд 75 ялтанд холбогдох 608.6 сая төгрөг, 2012 онд 67 ялтанд холбогдох 455.0 сая төгрөг, 2013 онд 46 ялтны 347.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна¹⁰. Сүүлийн гурван жилд үлдэгдэл гүйцэтгэх хуудасны тоо болон мөнгөн дүн жил дараалан буурсан нь харагдаж байна. /График 5/

График 5.



Тулгамдаж буй асуудал: Эрүүгийн хуулийн зарим зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын сонголт харьцангуй байдлаар буюу хуульд заасан ялын хүнд төрөл болох хорих ял, эсвэл ялын хамгийн хөнгөн төрөл болох торгох ялыг сонгох боломжтойгоор зохицуулагдсан. Энэ тохиолдолд шүүх гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзахаас илүүтэйгээр, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төлбөрийн чадварыг харгалзан ял оногдуулж байна. Энэ нь нийгмийн сэтгэл зүйд хууль, шүүх баян, ядуу хүнд ялгамжтай хандаж байна гэсэн хардлагыг тэрүүлдэг. Эрүүгийн хуульд хорих, торгох санцтай 33 зүйл анги байдаг байна¹¹.

Ялын хэрэгжилтэд тулгамдаж буй хамгийн гол асуудал нь торгох ялыг шүүхээс төлбөрийн чадваргүй, амжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой, оршин суух хаяггүй хүнд оногдуулдаг нь уг ялын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй бөгөөд түүнчлэн ялтан хуулийн алдаатай хийдлийг ашиглан график гарган, бага

¹⁰ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.

¹¹ Д.Зүмбэрэллхам, "Хорихоос өөр төрлийн ял болон хорих ялын альтернатив" илтгэл 2009 он.

хэмжээгээр төлбөрөө төлөн гүйцэтгэлийг удаашруулан ял завших оролдлого хийдэг байна.¹²

Жишээлбэл 20 сая төгрөгөөр торгуулсан этгээд төлбөрийн чадваргүйн улмаас сар бүр 100 мянган төгрөг төлж 3 жилд нийт 3.6 сая төгрөг төлж бусад төлбөрийг Эрүүгийн хуулийн 76.1 зааснаар хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсноор үндэслэн ялаас чөлөөлөх эрх зүйн зохицуулалт үйлчилж ял завших боломжийг бүрдүүлж байна.¹³

АНУ-д торгох ялыг хорих ба хянан харгалзах ялтай хамт хэрэглэдэг. Харин хөнгөн хэрэг, эрүүгийн зөрчлийн хувьд дангаараа бие даасан ял болж хэрэглэдэг. Торгох ялыг оноохдоо яллагдаж буй этгээдийн 7 хоногийн орлого, эд хөрөнгө, санхүүгийн байдлыг нягт шалган тогтоодог. Торгох ялын дээд хэмжээ нь иргэнд 5000 ам.доллараас дээшгүй, хуулийн этгээдийн хувьд 500.000 ам.доллараас дээшгүй байна. Муж улс бүрт харилцан адилгүй байдаг байна. Торгох ялаа төлж чадахгүй бол хорих ялаар сольдог байна.¹⁴

Хорихоос өөр төрлийн ялын төрлүүд дотор торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хамгийн хүндрэлтэй байдаг байна. Нэг талаас торгох ялыг эдэлж буй ялтан төлбөрийн чадвар муу, нөгөө талаас тэдгээр ялтныг ял завших боломж олгож буй өнөөгийн эрх зүйн тогтолцоо нь торгох ялын хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна.

Иймээс шийдвэр гүйцэтгэгч нарт хорихоос өөр төрлийн ялын төрлүүд дотроос биелүүлэхэд хамгийн хүндрэлтэй нь торгох ял¹⁵ байдаг байна. /График 6/

График 6.



Торгох ялын хэрэгжилтийг сайжруулахад эрх зүйн орчныг чангатгах, торгох ялыг хорихоос өөр бусад төрлийн ялаар сольж хохирлыг нөхөн төлүүлдэг тогтолцоонд шилжих нь илүү үр дүнтэй байж болох юм.

б. эд хөрөнгө хураах ял:

¹² Л.Алтансүх. “Ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт, тулгамдсан асуудал” Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл, 2013 он, №02, 10 дахь тал.

¹³ <http://www.criminology.mn/index.php?option=newsm&id=160&lang=1>

¹⁴ Б.Нямгомбо. “Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага” илтгэл, 2013 он.

¹⁵ Шүүхийн судалгаа мэдээлэл сургалтын хүрээлэн, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэгч нараас авсан социологийн судалгаа. 2014 он.

Монгол улсын Эрүүгийн хуульд эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартайгаар 42 гэмт хэрэгт оногдуулахаар хуульчилсан байдаг¹⁶. Монгол улсын Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэх бөгөөд хэрэгжилтийг хэрхэн хангахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94-95 дугаар зүйлд хуульчилж өгсөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар нь дараах зөвлөмжийн дагуу эд хөрөнгө хураах ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- 1) Шүүхийн шийтгэх тогтоол, гүйцэтгэх хуудсыг ахлах шийдвэр гүйцэтгэгч хүлээн авмагц шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол үйлдэж, харьяа тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.
- 2) Шийдвэр гүйцэтгэгч нь эд хөрөнгө хураах ялын гүйцэтгэх хуудас баримт бичгийг хүлээн авмагц шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт улсын орлогод хураах эд хөрөнгийг тусгайлан заасан эсэхийг нягтлан үзэж эд хөрөнгийн мэдүүлэг авна. Хэрэв тогтоох хэсэгт улсын орлогод хураах эд хөрөнгийг тусгайлан заасан бол гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор эд хөрөнгийг битүүмжилж, хураан, бусад ажиллагааг 30 хоногийн дотор дуусгавар болгоно.
- 3) Эд хөрөнгө хураах ялыг мөнгөн хэлбэрээр үндсэн ялын чанартай оногдуулахаар заасан бол төлбөрийг торгох ялын хэрэгжилтийг хангасан байдлаар барагдуулна.
- 4) Үндсэн ял дээр эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол ялтныг альхорих ангид ял эдэлж байгааг тодруулж, Тогтоол Гүйцэтгэх газраас лавлагаа авч хорих ангид нь ялтны шийтгэх тогтоолын хуулбарыг ажлын байраар хангах, хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийлгэх тухай албан бичгийн хамт хүргүүлнэ.
- 5) Эд хөрөнгө хураах ялын гүйцэтгэх баримт бичигт хийгдэх ажиллагаануудыг хийж, ялтантай уулзаж эд хөрөнгө хураах ялын төлбөрийг барагдуулах талаар дэлгэрэнгүй тайлбар авах. Үндсэн ял эдэлж байх явцад эд хөрөнгө хураах ялыг бүрэн биелүүлэх талаар анхаарч, нэмэгдэл ялыг төлбөрөөс нэн тэргүүнд биелүүлнэ.
- 6) Ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж ирүүлсэн хорих ангийн холбогдох баримтыг гүйцэтгэлийн хувийн хэрэгт хавсаргана. Эд хөрөнгийг хураах боломжгүй болсон бол эд хөрөнгийг хуульд заасны дагуу ялтаар нөхөн төлүүлнэ¹⁷.

Эд хөрөнгө хураах ял оногдуулсан шийтгэх тогтоолын гүйцэтгэлийн биелэлт

Сүүлийн гурван жилийн статистик мэдээнээс үзвэл 2011 онд 337 ялтанд холбогдох 94.1 сая төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 225 хүнд холбогдох 53.0 сая төгрөгийг бүрэн биелүүлж, 2012 онд 318 ялтанд холбогдох 95.8 сая төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа


¹⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. "Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудал" илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2014 он, 8 дахь тал.

¹⁷ <http://ncs.cd.gov.mn/index.php/2013-08-23-08-58-31/2013-08-23-09-00-07>

явуулж, 231 хүнд холбогдох 55.7 сая төгрөгийг бүрэн биелүүлсэн бол 2013 онд 585 ялтанд холбогдох 224.3 сая төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 492 ялтанд холбогдох 193.9 сая төгрөгийг бүрэн биелүүлсэн байна.¹⁸


Эд хөрөнгө хураах ялын гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 2011 онд 66.8 хувь, 2012 онд 72.6 хувьтай биелсэн бол 2013 онд 84.1 хувь болж өссөн байна¹⁹. /График 7/

График 7.



Биелүүлээгүй үлдэгдэл гүйцэтгэх хуудас 2011 онд 112 ялтанд холбогдох 41.1 сая төгрөг, 2012 онд 87 ялтанд холбогдох 40.1 сая төгрөг, 2013 онд 93 ялтны 30.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна²⁰. Сүүлийн гурван жилд үлдэгдэл гүйцэтгэх хуудасны тоо болон мөнгөн дүн жил дараалан буурсан нь харагдаж байна. /График 8/

График 8.



Тулгамдаж буй асуудал: Эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заахаар хуульчилсан боловч практикт ихэвчлэн мөнгөн хэлбэрээр оногдуулдаг. Жишээлбэл Эд хөрөнгө хураах ялтай 102 ялтнаас 64 ялтан буюу 84.7 хувь нь үндсэн ялаа хорих ангид эдэлж байгаа ба давхардсан тоогоор 59 ялтан буюу 81.9 хувь нь төлбөрийн чадваргүй, 24 ялтан буюу

¹⁸ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.

¹⁹ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.

²⁰ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.

33.3 хувь нь оршин суух хаяг тодорхойгүй, 58 ялтан буюу 80.5 хувь нь эд хөрөнгөгүй²¹ гэх шалтгаанаар биелэлт удааширдаг байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1.

Д.д	Биелэгдэхгүй байгаа шалтгаан	Тоогоор	Хувиар/давхардсан/
1	Хорих ял эдэлж буй	64	84.7
2	Төлбөрийн чадваргүй	59	81.9
3	Оршин суух хаяг тодорхой бус	24	33.3
4	Эд хөрөнгөгүй	58	80.5

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94.1 зааснаар Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг, эд хөрөнгө дансалсан буюу битүүмжилсэн актын хамтаар ялтны эд хөрөнгө байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд шүүх 3 хоногийн дотор хүргүүлнэ гэсэн заалт бүрэн хэрэгждэггүй, хорих ял дээр эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулсан гүйцэтгэх хуудас бүрэн бичигдэж ирдэггүй байна. Иймд нэмэгдэл ялын гүйцэтгэх хуудсыг хамтад нь шүүхээс бичүүлж ирүүлж байх шаардлагатай юм.

в. албадан ажил хийлгэх ял:

Эрүүгийн хуульд албадан ажил хийлгэх ялыг 44 гэмт хэрэгт оногдуулахаар хуульчилсан байдаг.

Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын гүйцэтгэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96, 97, 98 дугаар зүйлийн дагуу биелүүлдэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар нь дараах зөвлөмжийн дагуу албадан ажил хийлгэх ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- 1) Шүүхийн шийтгэх тогтоол, гүйцэтгэх хуудсыг хүлээн авмагц ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол үйлдэж, харъяа тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.
- 2) Албадан ажил хийх ялын гүйцэтгэх баримт бичигт ялтныг дахин гэмт хэрэг зөрчилд холбогдохгүй байх, оргон зугатахгүй байх талаар 2-оос доошгүй батлан даагчид хүлээлгэн өгсөн тухай баримт, шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэл, ялтанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 97, 98 дугаар зүйлийг тайлбарлан танилцуулж гарын үсэг зуруулан хууль тайлбарласан тухай тэмдэглэлийг хавсаргана.
- 3) Дүүргийн Засаг даргатай шийдвэр гүйцэтгэх алба “Албадан ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтныг ажиллуулах гэрээ” байгуулж, Засаг даргын тогтоосон ажлын байранд ялтныг хүлээлгэн өгч, ялтны цагийг засаг даргын тамгын газрын ажилтан бүртгэж баталгаажуулан шийдвэр гүйцэтгэгчид өгнө.

²¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. “Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2014 он, 15-16 дахь тал.

Албадан ажил хийж буй ялтныг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх ажлыг засаг даргын тамгын газар зохион байгуулна.

- 4) Шийдвэр гүйцэтгэгч цагийн бүртгэлийг үндэслэн ялын тооцоо хийх бөгөөд ажиллаж байгаа тухайн байгууллага дээр нь буюу албадан хөдөлмөр хийж байгаа эсэхийг ял эдлэх хугацаанд 30 цаг тутамд шалгаж, танилцан тэмдэглэл хөтөлж, хувийн хэрэгт хавсаргана. Ажилласан байгууллагаас ялтны засрал хүмүүжлийн тодорхойлолтыг авч хавсаргасан байна.
- 5) Ялтан ажлын цагаас хоцрох, ажил таслах, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүй дур мэдэн ажил орхих, ажлаас хойш суух, ажил олгогч, шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх, зөрчих, ялаас зайлсхийх зэрэг зөрчил гаргасан тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч энэ тухай тэмдэглэл хөтөлж сануулга өгнө. Дахин давтан зөрчил гаргавал албадан ажил хийх ялыг баривчлах ялаар солих тухай саналаа харьяа прокурорт албан бичгээр гаргана. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.²²

Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шийтгэх тогтоолын гүйцэтгэлийн биелэлт

Сүүлийн гурван жилийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээнээс үзвэл 2011 онд албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн 438 ялтанд холбогдох 129220 цагийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 420 ялтанд холбогдох 124610 цагийг бүрэн биелүүлсэн бол 2012 онд 445 ялтанд холбогдох 130487 цагийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 417 ялтанд холбогдох 124590 цагийг бүрэн биелүүлж, 2013 онд 467 ялтанд холбогдох 134317 цагийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 437 ялтанд холбогдох 127564 цагийг бүрэн биелүүлсэн байна.

Албадан ажил хийлгэх ялын гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 2011 онд 95.9 хувь, 2012 онд 93.7 хувьтай биелсэн бол 2013 онд 93.6 хувьтай биелсэн байна²³. Албадан ажил хийлгэх ялын шийдвэрийн гүйцэтгэл бусад төрлийн ялын гүйцэтгэлийн хувьтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа боловч бага зэрэг буурах хандлагатай байна. /График 9/

График 9.



²² <http://ncs.cd.gov.mn/index.php/2013-08-23-08-58-31/2013-08-23-09-00-07>

²³ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.

Биелүүлээгүй үлдэгдэл гүйцэтгэх хуудас 2011 онд 18 ялтанд холбогдох 4410 цагийн, 2012 онд 28 ялтанд холбогдох 5897 цаг, 2013 онд 30 ялтны 6753 цагийн ажил гүйцэтгэх үлдэгдэлтэй байна²⁴.

Тулгамдаж буй асуудал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96.2 –т “Шийдвэр гүйцэтгэх алба шийтгэх тогтоолыг хүлээж аваад 3 хоногийн дотор сум, дүүргийн засаг даргад танилцуулж аль байгууллагад албадан ажил хийлгэхийг тогтоолгож ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавина” гэж заасан бөгөөд эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд албадан ажил хийлгэх ялыг хаана, ямар байгууллагад ажиллуулах нь тодорхой бус зөрчилтэй байна.

Практикт аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга ажлын байраар хангах идэвхи сул, шийдвэр гүйцэтгэгчээс түүнд өдөр тутам биечлэн болон цаг ашиглалтанд хяналт бүрэн тавьж чаддаггүй, өнөөдрийн нөхцөлд хаана, ямар төрлийн ажил хийлгэх нь тодорхой бус байгаа юм²⁵.

2005 оны Хууль зүйн үндэсний төвийн Криминологийн судалгааны сектороос хийсэн “Албадан ажил хийлгэх боломжтой байгууллага, аж ахуй нэгж, ажлын байрны судалгаа”-гаар уг ялыг 129 байгууллага, улсын үйлдвэрийн газар, аж ахуйн нэгжид эдлүүлэх боломжтой гэж дүгнэсэн боловч одоогийн байдлаар уг ялыг ихэвчлэн гудамж талбай цэвэрлүүлэх гэх мэт нийтийн үйлчилгээний салбарт ажиллуулж болохоор судалгаа²⁶ гаргасан байдаг байна.

Засаг даргын зүгээс албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах ажлын байрны жагсаалтыг шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлж байх хуулийн зохицуулалттай болох шаардлагатай байна. Учир нь шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шалтгаалахгүйгээр ажлын байрны тодорхой бус байдлаас уг ялын хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна.

г. тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял

Монгол улсын Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албанд албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг 1-5 жил хязгаарлахаар хуульчилсан бөгөөд хэрэгжилтийг хэрхэн хангахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 99-100 дугаар зүйлд зааж өгсөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар нь дараах зөвлөмжийн дагуу эд хөрөнгө хураах ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

1. Шүүхийн шийтгэх тогтоол, гүйцэтгэх хуудсыг хүлээн авмагц ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол үйлдэж, харьяа тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.

²⁴ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.

²⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. “Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2014 он, 23 дахь тал.

²⁶ Монгол улсын Криминологийн судалгааны сектор. 2005 он


2. Ялтныг дуудан ирүүлж, ялын хугацаанд шүүхээс хориглосон албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулж болохгүйг анхааруулан, эрх, үүргийг нь танилцуулж, энэ тухай тэмдэглэл хөтөлнө. Ялтанд тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх олгосон баримт бичгийг эх хувиар нь хураан авч, эрх олгосон байгууллагад мэдэгдэнэ.
3. Шийдвэр гүйцэтгэгч эрх хасах ялын хэрэгжилтэнд зохих шалгалтыг тогтмол явуулж тэмдэглэл хөтлөн хувийн хэрэгт хавсаргана.
4. Ялтны эрх хасах ялын хугацаа дууссан бол шийдвэр гаргасан шүүх, хяналт тавьж буй прокурорт мэдэгдэнэ.
5. Ялтан ял эдлэхээс санаатай зайлсхийсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч ял солих тухай саналаа прокурорт гаргана. Шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шийтгэх тогтоолын гүйцэтгэлийн биелэлт

Сүүлийн гурван жилийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээнээс үзвэл 2011 онд тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял шийтгүүлсэн 291 ялтанд холбогдох 162841 хоногийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 71 ялтанд холбогдох 67487 хоногийг бүрэн биелүүлж, 2012 онд 506 ялтанд холбогдох 302563 хоногийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 148 ялтанд холбогдох 142741 хоногийн үлдэгдэлтэй байсан бол 2013 онд 896 ялтанд холбогдох 517812 хоногийн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 296 ялтанд холбогдох 269431 хоногийг бүрэн биелүүлсэн байна.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялын гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 2011 онд 24.4 хувь, 2012 онд 29.2 хувьтай биелсэн бол 2013 онд 33.0 хувь болж өссөн байна²⁷. /График 10/


График 10.



Биелүүлээгүй үлдэгдэл гүйцэтгэх хуудас 2011 онд 220 ялтанд холбогдох 95354 хоногийн, 2012 онд 358 ялтанд холбогдох 159822 хоногийн, 2013 онд 600 ялтанд холбогдох 248381 хоногийн үлдэгдэлтэй байна.²⁸ /График 11/

²⁷ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.

График 11.



Тулгамдаж буй асуудал: Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулсан тохиолдолд шүүхээс гүйцэтгэх хуудсыг харьяа шийдвэр гүйцэтгэх албанд харилцан адилгүй бичиж ирүүлж байна. Тухайлбал: Тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах, эрх хасах ялтай 139 ялтан ял эдэлж байгаагаас 47 буюу 33.8 хувь нь гүйцэтгэх хуудас бичигдсэн 92 буюу 66.2 хувь нь шүүхээс гүйцэтгэх хуудас бичигдэж ирээгүй тоон судалгаа байна.²⁹

Хорих болон баривчлах ял дээр тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол гүйцэтгэх баримт бичгийг шийтгэх тогтоолын хамт эсвэл ял эхлэх тоолох үед бичиж ирүүлэх асуудлыг нэг мөр болгож шийдвэрлэх шаардлагатай юм.

Өнөөгийн дагаж мөрдөж байгаа хуулиар эрх хасах ялаар шийтгүүлсэн этгээдийн 90 орчим хувь нь тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ял шийтгүүлсэн ялтан байдаг бөгөөд шийдвэр гүйцэтгэгч нь тэдгээрийн тээврийн хэрэгсэл жолоодохгүй байгаа хугацааг шалгахад хүндрэлтэй байдаг байна. Өөрөөр хэлбэл тус ялаар шийтгүүлсэн ялтан тээврийн хэрэгсэл жолоодох, жолоодохгүй байгааг шийдвэр гүйцэтгэгч хэрхэн хянах зэрэг нь тодорхойгүй байгаа юм.

1.3. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл: шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт, тулгамдаж буй асуудал

Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа олон жилийн туршид хэд хэдэн хуулийн холбогдох заалтаар зохицуулагдаж байсан бөгөөд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль” гарч 1994 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөгдсөн нь энэ чиглэлийн анхны бие даасан хууль болсон. 1996 онд “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль”-д эд хөрөнгийн холбогдолтой иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэрийг биелүүлэх тусгай бүлэг нэмэгдэн батлагдаж, энэ үеэс эхлэн Монгол Улсад Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааны эрх зүйн нэгдсэн орчин бүрдсэн байна. Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн

²⁸ Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.

²⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. “Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2014 он, 20 дахь тал.

шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Иргэний хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудыг баримтлан явуулж байна.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд заавал оролцох субъект нь шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч бөгөөд төлбөр авагч, төлбөр төлөгчийн эрх үүрэг энэ байгууллагаар дамжин хэрэгжиж байна. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн болон тусгай зарчим болох хуулийн өмнө эрх тэгш байх, хууль дээдлэх диспозитив буюу зөвшилцөх, мэтгэлзэх, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр заавал биелэгдэх зэрэг зарчмууд онцлог байдлаар хэрэгжиж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгалаа олсон байдаг.³⁰

а. төлбөр гаргуулах ажиллагаа, хэрэгжилт

Эрх зүйн зохицуулалт: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн хөндөгдсөн эрхийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, нөгөө талаас төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааг хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд албадан гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэдэг онцлогтой. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа гэдэг нь иргэний хэргийн талаарх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа журам юм. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг хамгаалах явцад үүссэн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны нийлбэр мөн.³¹

Иймээс иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өвөрмөц онцлог үе шатуудыг авч үзвэл:

1. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд оролцогч субъектуудын хувьд онцлогтой. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал байх субъект нь шүүх бөгөөд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгчийн хооронд үүсэж бий болох харилцаа шүүхээр дамжиж бий болдог. Тэгвэл иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд заавал оролцох субъект нь шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгч бөгөөд төлбөр авагч, төлбөр төлөгчийн эрх, үүрэг энэ байгууллагаар дамжин хэрэгжиж байдаг онцлогтой.
2. Эдгээр харилцааг зохицуулж буй эх сурвалжаараа ялгагдах онцлогтой. Тухайлбал: нэхэмжлэлийг хүлээн авах иргэний хэрэг, иргэний хэрэг үүсгэх ажиллагааг ИХШХШТХ-аар зохицуулж байгаа бол төлбөр төлөгчийн орон байранд нэвтрэн орох, үзлэг нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураан авах гэх мэт ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрөлжсөн хуулиар зохицуулж байх жишээтэй.

³⁰ Э.Нармандах “Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” <http://issuu.com/oyunsanaasanaa/docs/narmandah>

³¹ Тэгшжаргал “Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй зарим асуудал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох” илтгэл 2010 он

3. Эдгээр эрх зүйн зохицуулах хууль зүйн үр дагавар нь өөр өөр байдаг. Тухайлбал: шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эцсийн зорилго нь шүүхийн шийдвэрийг бодитойгоор биелүүлэхэд оршдог.

Төлбөр гаргуулах чиглэлээр дараах үйл ажиллагааг явуулна.³²

1. Төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, худалдан борлуулах
2. Төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах, өртэй этгээдийн бүртгэлд бүртгэх
3. Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийлгүүлэх
4. Төлбөр төлөгчийн бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах
5. Шийдвэрт нэр заасан тодорхой эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлнэ.

Төлбөр төлөгч иргэнээс төлбөр гаргуулах ажиллагаа

Төлбөр төлөгч иргэнээс төлбөр гаргуулах ажиллагаа нь төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулахаас ялгагдах зарим онцлогтой. Шүүхийн тогтоолд заасан төлбөрийг төлбөр төлөгч иргэний бүх төрлийн хөрөнгөнөөс гаргуулна.³³

Тухайлбал:

- Төлбөр төлөгч- иргэний өмчлөлийн эд хөрөнгө болох түүний банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө
- Хувьцаа бонд зэрэг үнэт цаас
- Үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө
- Бусад хөрөнгө

Мөн төлбөр төлөгч иргэнээс төлбөр гаргуулах өөр нэг хэлбэр бол түүний цалин хөлс түүнтэй адилтгах бусад орлогоос тооцох явдал юм. Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлого нь банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд ордог бол орлогыг хасаж төлбөрийг шилжүүлнэ.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа:

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг шийдвэр гүйцэтгэгч тухайн банк, банк бус санхүүгийн байгууллагад

³² “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 34 дүгээр зүйл

³³ А.Лхагваа “Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2004 он 176-р тал

хүргүүлэх бөгөөд түүнийг хүлээн авсан байгууллага нь төлбөр төлөгчийн данснаас төлбөрийг гаргаж, 3 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу мэдэгдэл өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлнэ. Төсөвт байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй бол түүнийг санхүүжүүлдэг байгууллагад төлбөрийг гаргуулах мэдэгдлийг хүргүүлэх буюу дараагийн төсөвт нэмж тусгахыг шаардана. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх явцад бэлнээр хадгалагдаж байгаа мөнгөн хөрөнгө илэрвэл түүнийг хураан авна. Төлбөрт гаргуулсан бэлэн мөнгийг тэр өдөрт нь төлбөрийн шаардлагын хэмжээгээр, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тооцон авч төлбөр авагчид шилжүүлнэ. Төлбөр төлөгч нь банк байх тохиолдолд тухайн арилжааны банкны Монгол банк дахь харилцах данснаас хасалт хийх буюу төлбөрийн шаардлагын хэмжээгээр дансны зарлагын гүйлгээг битүүмжлэн төлбөрийг гаргуулна.³⁴

- **Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулах:**

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд түүний өмчлөлд хамаарах гүйлгээнээс хассан буюу гүйлгээнд оруулахыг хязгаарласнаас бусад эд хөрөнгөнөөс хаана, юунд ашиглагдаж байгаагаасаа нь үл хамааран төлбөрийг гаргуулна.³⁵

- **Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн бусад байгаа эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах:**

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн мөнгөн болон бусад эд хөрөнгө бусад байгаа эсэхийг тодруулж, хэрэв байвал түүнээс төлбөрт шаардагдах хэмжээгээр гаргуулна. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банкин дахь харилцах данс, хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөр гаргуулж болно.³⁶

- **Төлбөр төлөгч-хуулийн этгээд өөрчлөгдөн зохион байгуулагдах үед төлбөр гаргуулах журам:**

Төлбөр төлөгч-хуулийн этгээд нийлэх, нэгдэх, тусгаарлах, хуваагдах, өөрчлөх замаар өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу тухайн байгууллагын мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.³⁷

- **Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах:**

Төлбөр төлөгч-хуулийн этгээд татан буугдах, дампуурах зэргээр үйл ажиллагааг нь зогсоох үед гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлж Дампуурлын тухай хуульд заасан журмын дагуу төлбөр авагчид болон гүйцэтгэх баримт бичиг өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд

³⁴ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 57 дугаар зүйл

³⁵ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 58 дугаар зүйл

³⁶ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 60 дугаар зүйл


³⁷ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 62 дугаар зүйл

төлбөрийг шилжүүлэхээс гадна хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь сэргэн төлбөрийн чадвартай болсон ч төлөвлөгөөний хугацаа дуусахад төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг шийдвэр гүйцэтгэх албанд буцаан шилжүүлнэ.³⁸

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 12 жилийн хугацаанд иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй холбоотой 279847 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулан явуулсан байна. Нийт гүйцэтгэх баримт бичгийн буюу 80.8 хувь нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр байна.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 27716 гүйцэтгэх баримт бичиг байгаагийн 72.3 хувь нь иргэнд олгох, 27.7 хувь нь хуулийн этгээдэд олгох төлбөр байгаа ба нийт мөнгөн дүнгийн 75.5 хувь нь өндөр үнийн дүнтэй /100 саяаас дээш/ гүйцэтгэх бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.³⁹

График 12.



Байгууллагад олгох төлбөр.⁴⁰

Тайлбар: 2011 онд нийт биелүүлбэл зохих 8700 гүйцэтгэх хуудаснаас 6405 буюу 73.6 хувийг бодитой биелүүлж, 2295 буюу 26.4 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй, 2012 онд нийт 7943 биелүүлбэл зохих гүйцэтгэх хуудаснаас 5696 буюу 71.7 хувийг бодитой биелүүлж, 2247 буюу 28.3 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй, 2013 онд нийт 8378 гүйцэтгэх хуудаснаас 5889 буюу 70.3 хувийг бодитой биелүүлж, 2489 буюу 29.7 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй байна. /График 12/

Байгууллагад олгох төлбөр 2011 онд биелүүлбэл зохих 148505883.4 тэрбум төгрөгөөс 45.6 хувийг бодитой биелүүлж 80933460.9 тэрбум буюу 54.4 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй, 2012 онд биелүүлбэл зохих 166407164.7 тэрбум төгрөгөөс 41.7 хувийг бодитой биелүүлж 58.3 хувь буюу 96933335.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, 2013 онд биелүүлбэл зохих 325142423.6 тэрбум төгрөгөөс 21.9 хувийг биелүүлж 78.1 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй байна.

³⁸ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 63 дугаар зүйл

³⁹ Д. Дамдинцэрэн “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал шинэчлэлийн хэрэгцээ, шаардлага” илтгэл 2014 он

⁴⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдээ /2011-2013 он/

*Хүснэгт 2.***Байгууллагад олгох төлбөрийн үлдэгдэл**

Төрөл	2011 он		2012 он		2013 он	
	Г/х	эзлэх хувь	Г/х	эзлэх хувь	Г/х	эзлэх хувь
Татварын	120	5.2	99	4.4	146	5.9
У/тэмдэгтийн хураамжийн	120	5.2	343	15.3	214	8.6
Н/даатгалын	76	3.3	49	2.9	39	1.6
Гаалийн	2	0.1	2	0.08	0	0
Банкны	631	27.5	607	27	578	23.2
БХЗХТБААлбаны	98	4.3	115	5.1	275	11
Бусад	1248	54.4	1032	45.4	1237	49.7
Нийт дүн	2295	100	2247	100	2489	100


Тайлбар: Сүүлийн 3 жилийн биелүүлээгүй гүйцэтгэх хуудасны харьцуулалтаас харахад банкны байгууллагын нэхэмжлэлийн хувьд хамгийн их үлдэгдэлтэй буюу 23-27.5 хувийг эзэлж байна. Мөнгөн дүнгээр харьцуулахад хамгийн их үлдэгдэлтэй нь 91725871.2 тэрбум төгрөг буюу 36.1 хувийг татварын байгууллагын нэхэмжлэлтэй гүйцэтгэх хуудас эзэлж байна. *Хүснэгт 2/*

Тулгамдаж буй асуудал: Төлбөр төлөгч этгээд удаан жил үйл ажиллагаа явуулаагүй, төлбөрт гаргуулах эд хөрөнгөгүй, төлбөрийн чадваргүй, төлбөр төлөхөөс санаатайгаар зайлсхийх, эд хөрөнгөө бусдад барьцаалах, шилжүүлэх, битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, төлбөр төлөгч хуулийн этгээдийн харилцах дансны талаарх мэдээллийг арилжааны банк ирүүлэхгүй байх, татвар төлөгч хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлээгүй үүсгэн байгуулагчийн гэрийн хаягаар хуулийн этгээд үүсгэсэн, оршин суух тодорхой хаяггүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хуульд заасан албадлагын арга хэмжээ зохих үр дүнд хүрэхгүй байна.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу төлбөр барагдуулах ажиллагааг тухайн жилд гүйцэтгэвэл зохих төлбөрийн хэмжээгээр тооцон хэсэгчлэн төлөх төлбөрийн хэмжээг тогтоодог боловч төлбөр төлөгчөөс тогтоосон графикийг зөрчсөнөөс өр төлбөр ихээр хуримтлагдаж, он дамжин үргэлжилж, удаашрах нөхцөл болж байна.

Мөн түүнчлэн төлбөрөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр цагдаа, прокурор, шүүхийн байгууллагад холбогдох материалыг шилжүүлдэг боловч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг, төлбөр төлөгч хуулийн этгээдээс цаг хугацаа хожих, өөрт ашигтай нөхцөл байдлыг бий болгох зорилгоор удаа дараа нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлдэг.

*Иргэнд олгох төлбөр:**График 13.*



Тайлбар: 2011 онд нийт биелүүлбэл зохих 7555 гүйцэтгэх хуудаснаас 4691 буюу 62.1 хувийг бодитой биелүүлж, 2864 буюу 37.9 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй, 2012 онд нийт 7587 биелүүлбэл зохих гүйцэтгэх хуудаснаас 4998 буюу 65.9 хувийг бодитой биелүүлж, 2589 буюу 34.1 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй, 2013 онд нийт 7560 гүйцэтгэх хуудаснаас 5064 буюу 67 хувийг бодитой биелүүлж, 2496 буюу 33 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй байна. /График 13/

Иргэнд олгох төлбөр 2011 онд биелүүлбэл зохих 24824016.0 тэрбум төгрөгөөс 51.4 хувийг бодитой биелүүлж 12058827.7 буюу 48.6 хувийн биелүүлээгүй үлдэгдэлтэй, 2012 онд биелүүлбэл зохих 30223425.5 төгрөгөөс 41.4 хувийг бодитой биелүүлж 58.6 хувь буюу 17700063.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, 2013 онд биелүүлбэл зохих 39732602.2 тэрбум төгрөгөөс 45.08 хувийг бодитой биелүүлж 54.9 хувийг буюу 21819059.4 биелүүлээгүй үлдэгдэлтэй байна.

Тулгамдаж буй асуудал: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн төлбөр төлөгчийн төлбөрийн чадвараас шууд шалтгаалдаг бөгөөд нэхэмжлэгчээс эд хөрөнгийг шүүхийн шатанд хамгаалуулах арга хэмжээг авхуулаагүйгээс төлбөр төлөгч эд хөрөнгөө нуух, бусдад шилжүүлж үрэгдүүлснээс төлбөрт гаргуулах эд хөрөнгө тогтоогдохгүй байх нөгөө талаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болон гуравдагч этгээдэд ажиллагааны үе шат бүрт гомдол гаргах боломжийг олгосон нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах томоохон шалтгаан болж байна. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээлээс гадна энэ чиг үүргийг гүйцэтгэж буй шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал, тэдний ажиллах орчин, нийгэм эдийн засгийн баталгаа хангалтгүй байна.

Хуулийн этгээд татан буугдсан өөрчлөн зохион байгуулагдаж буй тохиолдолд хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогсож, эсвэл зогсохгүйгээр шинэ хуулийн этгээд үүсэн бий болж байгаад шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож байсан тал болох төлбөр төлөгч хуулийн этгээд өөрчлөгдөж шинэ төлбөр төлөгч оролцох нь төлбөр гаргуулахад хүндрэлтэй байдаг.

Төлбөр төлөгч хуулийн этгээдийн гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс, хэрэг гүйцэтгэгчид шилжүүлсэн ч төлбөрийг барагдуулах ажиллагаанд хяналт тавих, төлбөрийг хэрхэн барагдуулж байгаа талаар мэдээлэл авах, төлбөрийг бүрэн гүйцэтгэсэн талаар мэдээлэл авсан тухай бүр нь гүйцэтгэх ажиллагааг дуусгавар

болгох тухайн шийдвэр гаргах, татан буулгах комисс болон хэрэг гүйцэтгэгчийн буруу үйл ажиллагааны талаар гомдол гаргах эрхийг шийдвэр гүйцэтгэгчид олгох.

Хүүхдийн тэтгэлэг тогтоох

Эрх зүйн зохицуулалт: Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар зохицуулна. Хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээ хэрэгжүүлээгүй тэтгэлэг төлөгч нарт захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна. Тухайлбал:

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль /25 дугаар зүйл/
- Захиргааны хариуцлагын тухай хууль /30⁴ дүгээр зүйл/
- Эрүүгийн хууль /120 дугаар зүйл/

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт: Хүүхдийн тэтгэлгийн төлбөрийг урамшууллаас чөлөөлөхөөр зохицуулсан өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 27716 гүйцэтгэх баримт бичиг байгаагийн 9630 гүйцэтгэх хуудас буюу 34,7 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой байна.⁴¹

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй холбоотой 279847 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулан явуулсан байна. Нийт гүйцэтгэх баримт бичгийн буюу 226116 буюу 80.8 хувь нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр, үүнээс 109240 гүйцэтгэх баримт бичиг буюу 31.6 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой байна.⁴²

График 14.



Тайлбар: Шүүхээс ирсэн иргэнд олгох төлбөрийн гүйцэтгэх хуудсыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд 2011 онд иргэнд олгох төлбөрийн 42 хувь, 2012 онд 34.5 хувь, 2013 онд 31.1 хувийг хүүхдийн тэтгэлгийн төлбөр эзэлж байна. /График 14/

График 15.

⁴¹ Я.Батгэрэл “Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, анхаарах асуудал” илтгэл 2014 он

⁴² Д. Дамдинцэрэн “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал шинэчлэлийн хэрэгцээ, шаардлага” илтгэл 2014 он





График 16.



Тайлбар: Улсын хэмжээнд хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулалт нь **2011** онд бодитой биелэгдсэн 11.6 хувь, биелүүлээгүй үлдэгдэл 9609 буюу 88.4 хувь **2012** онд бодитой биелэгдсэн 12.8 хувь, биелүүлээгүй үлдэгдэл 9572 буюу 87.2 хувь, **2013** онд бодитой биелэгдсэн 14.5 хувь, биелүүлээгүй үлдэгдэл 9704 буюу 85.5 хувь байна. Мөн 2014 оны эхний 8 сарын байдлаас үзвэл бодитой биелэгдсэн 1243 буюу нийт биелүүлбэл зохих гүйцэтгэх хуудасны 12.9 хувь, биелүүлээгүй үлдэгдэл 8387 буюу 87.1 хувь байна.⁴³ / *График 16*

Тулгамдаж буй асуудал: Хүүхдийн тэтгэлэгийн гүйцэтгэлийн ажиллагаа удааширч байгаа шалтгаан нь энэ ажиллагааг гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчидэд урамшуулал олгодоггүй. Ийм учраас шийдвэр гүйцэтгэгч нар урамшуулалтай ажиллагаанууд эхэлж гүйцэтгэж улмаар хүүхдийн тэтгэлэгийн асуудал нэлээн хойш тавигддагаас гадна хүүхдийн тэтгэлэг-амжиргааны түвшингийн тодорхой хувь хэмжээгээр сар бүр тэтгэлэг гаргуулах ажиллагаа явагддаг ч ихэнх тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээс тогтоосон тэжээн тэтгэх үүргээс зайлсхийх, тэтгэлэгийн хуримтлал үүсгэдэг тул гүйцэтгэл бүр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах шаардлага үүсч, үүнтэй холбоотой ажиллагааны зардал шаарддаг.

⁴³ Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн 2011,2012,2013 оны мэдээ

Тэтгэлэг сар бүр тогтмол нэмэгдэж байдаг, мөн амжиргааны доод түвшингийн хэмжээ жилд 1-2 удаа нэмэгддэг. Энэ нь хөдөлмөр эрхэлдэггүй хөрөнгө орлогогүй тэтгэлэг төлөгч нарт хүнд байдаг.

Эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах

Дараахь үндэслэл байвал төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэн, барьцаалах, хураах ажиллагаа явуулна.⁴⁴

1. Эд хөрөнгийг төлбөр төлөгчид шилжүүлэх, эсхүл худалдан борлуулах, эд хөрөнгийг хамгаалах
2. Төлбөр төлөгчийн өөрт нь байгаа болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах тухай гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх
3. Төлбөр төлөгчийн болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг хураах тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

Гадаад валют, Монгол Улсын мөнгөн тэмдэгт, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн гоёл чимэглэл, түүх соёлын хосгүй болон бусад үнэт дурсгал зүйлийг заавал хураан авна.

Төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг хуваарилан олгох ажиллагаа

Төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны төгсгөлийн шат нь төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг төлбөр авагчдад хуваарилан олгох явдал юм. Төлбөр төлөгчөөс төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг төлбөр авагчид олгохын өмнө шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны зардлыг эхний ээлжинд суутган тооцдог. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад гарсан бодит зардлын талаар шийдвэр гүйцэтгэгч, төлбөр авагч буюу хохирогчид урьдчилан танилцуулвал зохино.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд.⁴⁵

1. Албадан дуудлага худалдаа явуулсан
2. Өмчлөх эрх шилжих хүртэл эрхлэн хамгаалагч үл хөдлөх эд хөрөнгийг хамгаалсан, засварласан
3. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдох тогтмол төлөгдөх зээлийн хүү, захиргааны зардал зэрэг
4. Ипотекийн эрхтэй этгээдэд төлөх төлбөр хамаарагдана.⁴⁶

Иргэнд олгох бол 3 жил, хуулийн этгээдэд шилжүүлэх бол 1 жил хадгалах бөгөөд шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд байгаа мөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно. Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг дараалал харгалзахгүй олгодог байна.

Тэтгэлэг төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийсэн иргэн, хуулийн этгээд түүнийг төлбөр авагчид бэлнээр олгох буюу хадгаламжинд нь шилжүүлнэ.⁴⁷

⁴⁴ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 36 дугаар зүйл

⁴⁵ А.Лхагваа “Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2004 он 166-р тал

⁴⁶ А.Лхагваа “Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2004 он 181-р тал

⁴⁷ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 75 дугаар зүйл.1.1

Хэрэв тэтгэлгийн мөнгө банкаар дамжин шийдвэр гүйцэтгэх албаны дансанд орж ирсэн бол тухайн мөнгийг тэтгэлэг авагчид бэлнээр олгох ба түүний хадгаламжийн дансанд, өөрийнх нь заасан дансанд шилжүүлнэ. Төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгийг төлбөр авагч хуульд заасан журмаар бүрэн олгосон бол төлбөрийг бодитой биелүүлсэнд тооцож, төлбөр төлөгчид шийдвэр гүйцэтгэсэн тухай төлбөр авагчид зохих хөрөнгө, мөнгө, эрхийг шилжүүлсэн тухай баримт бичгийг тус тус гардуулж, гүйцэтгэх баримт бичгийг хаадаг.

б. Үл хөдлөх эд хөрөнгийн албан дуудлага худалдаа явуулах ойлголт, журам

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог нь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн эдийн болон эдийн бус эрхэд халддаг төрийн албадлагын арга хэмжээний нэг бие даасан төрөл юм. Энэхүү хуулиар тусгайлан эрх олгогдсон албадлагын арга хэмжээний дагуу төлбөр төлөгчийн эдийн баялагтай холбоотой эрхэд халддаг гүйцэтгэлийн ажиллагааны дээд хэлбэр нь үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөнөөс албадан төлбөр гаргуулах үйл ажиллагаа хамаардаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практикт хэрэгжүүлэхэд хамгийн хүндрэлтэй асуудал бол үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг амжилттай зохион байгуулах явдал юм. Энэ нь дийлэнх төлбөр гаргуулах ажиллагааны объект нь үл хөдлөх хөрөнгө байдагтай холбоотой. Үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдааг Иргэний хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулиар тус тус зохицуулна.

Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч албадан дуудлага худалдааг явуулах тухай болон хугацааг товлосон тогтоол гаргаж үл хөдлөх эд хөрөнгийн нэр, хэмжээ, зориулалт, байршил болон анхны үнэ, өмчлөгчийн тухай, албадан дуудлага худалдаа явуулах огноо, цаг, хаяг, үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар, шаардлагатай бусад баримт бичиг, мэдээллийн талаар заасан байна.⁴⁸

Албадан дуудлага худалдаа зохион байгуулах биелэлтийг хангах ажлын хүрээнд:

- Төлбөр төлөгч, төлбөр авагч гуравдагч этгээд шаардлагатай бол шинжээчийн оролцоотойгоор тухайн албан дуудлага худалдаанд оруулах үл хөдлөх эд хөрөнгийн үнийг харилцан тохиролцох
- Албадан дуудлага худалдаа явуулах хугацаа, хаана явагдах, ямар журмаар бүртгэх, үл хөдлөх хөрөнгийн үнэ, дэнчингийн хэмжээ зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах
- Тухайн үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх
- Оролцогчдоор журмын дагуу дэнчин төлүүлэх зэрэг ажлууд хийгдэнэ.

Албадан дуудлага худалдаа зохих журмын дагуу явагдаж дууссаны үр дүнг илтгэх гол үзүүлэлэлт бол тухайн дуудлага худалдааны орлогыг хуваарилах, үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх явдал юм. Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны үр дүнд өмчлөх эрх тодорхой этгээдэд шилждэг.

⁴⁸ Ш.Энхжаргал “Үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” илтгэл 2013 он

Худалдан борлогдоогүй хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар үл хөдлөх эд хөрөнгийг 2 дахь албадан дуудлага худалдаанд оруулах анхны үнийг “шаардлагыг хангахад хүрэлцэхүйц” хэмжээгээр тогтооно гэж заасан нь ямар нөхцлийг үндэслээд хэдэн хувиар бууруулахыг тодорхойлон тусгаагүй. Өөрөөр хэлбэл шаардлагыг хангахад хүрэлцэхүйц хэмжээ гэдгийг шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахад хичнээн төгрөгийн зардал гарсан, гарсан зардлыг хэрхэн хасаж төлбөрт тооцож байгаа, зөрүүг яаж тооцож төлбөр төлөгчид буцааж байгаа зэрэг санал болгох тухай үнийг тогтоосон баримт нотолгоог хангалттай бүрдүүлэх, энэ талаарх хурлын тэмдэглэлийг үйлдэж, төлбөр төлөгч болон төлбөр авагч нараар баталгаажуулах шаардлагатай. Шүүх үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаатай холбоотой нэхэмжлэл, маргааныг хянан шийдвэрлэхдээ Иргэний хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг тус тус баримтлан хянан шийдвэрлэж байна.⁴⁹

Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ гэж заасан. Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг явуулахдаа 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хуулийн зарим зүйл, заалтыг баримтлан зохион байгуулах нь зүйтэй байна. Тус хуулиар дуудлага худалдааны үнийг тогтоох, дуудлага худалдаа болоогүй гэж тооцох үндэслэл, дуудлага худалдааг дахин явуулах, үнэ бууруулах, өмчлөл шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.6 дах хэсэгт “Дуудлага худалдаа явуулахаар шүүхээс томилогдсон этгээд дуудлага худалдааг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор явуулна” гэж заасныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 185 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай шүүгчийн захирамж гарсан өдрөөс гэж ойлгодог ба шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай захирамж нь тухайн шийдвэр давж заалдах болон хяналтын шатны шүүхээр хянагдсаны эцэст, эсвэл эдгээр шүүхүүдээр хянуулах хугацаа дууссан тохиолдолд бичигддэг тул дуудлага худалдааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлнэ. Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дах хэсэгт “Албадан дуудлага худалдаа явуулах тухай ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоол гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор явуулна” гэж заасан байдаг. Энд Иргэний хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зөрчилдөж байгаа бөгөөд аль хуулийг хэрэглэх нь эргэлзээтэй байдаг. Практикт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн заалтыг баримтлан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж байна.⁵⁰

Тулгамдаж буй асуудал: Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааны талаархи Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Иргэний хуульд заасан заалтууд хоорондоо зөрчигдөж амьдрал практик дээр хэрэгжихгүй байх тохиолдол цөөнгүй гарч байна. Ялангуяа төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээд шүүхэд үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны үнэ, үнэлгээтэй холбоотой гомдол гаргахад анхан болон давах, хяналтын шатны шүүгчид дээрх хуулийн заалтуудыг

⁴⁹ Ш.Энхжаргал “Үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” илтгэл 2013 он

⁵⁰ Э.Нармандах “Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” <http://issuu.com/oyunsanaasanaa/docs/narmandah>

өөрсдийн дотоод итгэлд тулгуурлан ижил төрлийн нэхэмжлэлийг өөр өөрөөр шийдвэрлэх тохиолдол цөөнгүй гардаг. Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дугаар зүйлд дараах тохиолдолд шинжээчээр үнэлүүлнэ гээд 37.2.2-д төлбөр төлөгч, төлбөр авагч, өмчлөгч Иргэний хуулийн 177.1 заасны дагуу тохиролцоогүй бол үл хөдлөх эд хөрөнгийг шинжээчээр үнэлүүлнэ гэжээ. Жишээлбэл Барьцааны байр 4 хүний эзэмшилд бүртгэлтэй байгаа тохиолдолд эзэмшигчээс заавал үнэлгээний талаар санал авна гэсэн үг. Санал тохиролцуулах ажиллагааг явуулахгүй бол шүүхээс үнэлгээ хүчингүй болон шийдвэрлэдэг тул эзэмшигч төлбөр төлөгч нар нь үнийн санал өгөхгүй, зориуд зайлс хийх тохиолдол гарч болзошгүй бөгөөд энэ шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах нэг хүчин зүйл болох тул үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг шууд шинжээч томилон гүйцэтгүүлдэг байх нь илүү боломжтой хувилбар юм.

1.4. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл: эрх зүйн зохицуулалт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт, тулгамдаж буй асуудал

Монгол Улсын Үндсэн хуульд: “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”⁵¹ байхаар хуульчилж мөн “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”⁵² гэж тусгасан нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцуулахаар заасан байна. Иргэн захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...”⁵³

Захиргааны хэргийн шүүх

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно” гэж заасныг үндэслэж Улсын Их хурлаас 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”, “Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль”-ийг тус тус баталж улмаар “Шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуульд аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх, түүний бүрэн эрх, ерөнхий шүүгчийн бүрэн эрх, дагнасан шүүхийн үйл ажиллагааг зохицуулсан бусад асуудлыг нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан

⁵¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12. 1992.01.13

⁵² Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1. 1992.01.13

⁵³ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14. 1992.01.13

нь Монгол улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдан ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2010 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар дэмжсэн Монгол Улсын шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс шүүх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд орж, 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Шүүхийн тухай хуульд заасны дагуу давж заалдах шатны шүүх нь шүүн таслах ажлын төрлөөс хамааран эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон тойргоор өөрчлөн байгуулагдаж байна. Энэ хүрээнд Захиргааны хэргийн анхан шатны 20 шүүх (*Булган аймаг Орхон аймагтай нэгдэж, Сэлэнгэ аймаг Дархан аймагтай нэгдсэн*), давж заалдах шатны 1 шүүх ажиллаж байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг захиргааны байгууллага, албан тушаалтан биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгэх нь иргэдийн төрд итгэх итгэлийг бий болгох, нөгөө талаас захиргааны байгууллагын хууль бус үйлдлийг таслан зогсоох ач холбогдолтой.

Улсын Их Хурлаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлан гаргасан учраас Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн талаар хуульд анх тусгагдаагүй байна. Харин Улсын Дээд Шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10.1.1-д заасан гүйцэтгэх баримт бичигт “Иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр”-т захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хамаарахаар тайлбарласнаар Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн “Иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа”⁵⁴ гэсэн хэсгийн хэм хэмжээгээр зохицуулдаг болсон байна. Улмаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж 4 дүгээр зүйлийн 4.1-д “захиргааны” гэж үг нэмжээ. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна” гэж зааснаас үзвэл захиргааны шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагаа иргэний шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаатай нэгэн адил зарчмаар явагдахаар зааж өгснөөс өөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрхэн явуулах талаар нарийвчилсан хуулийн зохицуулалт байхгүй байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил журмаар явагдана.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааны тал нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан, эрх хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд байна.


Захиргааны хэргийн шүүхээс гаргах шийдвэр:

⁵⁴ Улсын Дээд Шүүхийн 2003 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоол

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1. Маргаан бүхий захиргааны акт хууль бус болохыг тогтоож, түүнийг хүчингүй болгосон; 70.2.2. Эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож хүлээн зөвшөөрсөн; 70.2.3. Захиргааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн; 70.2.4. Захиргааны актыг гаргахгүй байгаа явдал болон эс үйлдэхүй нь хууль бус гэж тогтоогдсон бол шаардагдах захиргааны акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах; 70.2.5. Төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг багасгасан; 70.2.6. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчлөх, хасах 70.2.7. Хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлэх;

Эдгээрээс өөрөө аяндаа биелэгдэх шинж чанартай шийдвэрийг албадан гүйцэтгэх шаардлагагүй. (70.2.1, 70.2.2, 70.2.3, 70.2.5) Харин үлдсэн шийдвэрүүдийг захиргааны байгууллага, албан тушаалтны зүгээс биелүүлэхгүй байгаа нөхцөлд албадан гүйцэтгүүлэх шаардлага гарна.

График 17.



Захиргааны шийтгэврээр оногдуулсан торгуулийн биелэлтийг авч үзвэл өнгөрсөн 10 жилд нийт 4522 гүйцэтгэх хуудсын 3203-ийг бодитоор биелүүлсэн нь 70.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Харин гүйцэтгэлийн хувь 2004 он (45.8%)-оос 2013 (90.2%) он хүртэл тогтмол өсөлттэй байна. /График 17/

График 18.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2010 оноос улсын хэмжээнд захиргааны шүүхийн шийдвэртэй гүйцэтгэх хуудсын бүртгэл хөтөлдөг болсон байна. Энэ 5 жилийн хугацаанд 413 захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй хуудас шүүхээс ирснээс 298 буюу 72.1 хувийг бүрэн гүйцэтгэсэн байна. Тодруулбал 4 гүйцэтгэх хуудас тутмын 1 нь биелээгүй байна. /График 18/

Захиргааны хэргийн шүүхээс гаргасан шүүхийн шийдвэрийг хариуцагч нь биелүүлэхгүй тохиолдолд ИХШХШТХ-д зааснаар албадан биелүүлдэг байна. Иймд Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хэрэгжилт, тулгамдсан асуудал сэдэвт нийтлэлийн судалгааны дүнгээс үзвэл.⁵⁵

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд 2014 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 34 иргэн 32 хуулийн этгээдээс хандсан 62 шүүхийн шийдвэр биелэгдээгүй Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд ажиллагаа хийгдэж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа шийдвэрийг маргааны төрлөөр нь авч үзвэл:

- Газрын асуудлаар эрх бүхий албан тушаалтан захирамж, тушаал гаргахгүй, өргөдлийг шийдвэрлэхгүй байгаа -23 маргаан
- Ашигт малтмалын лицензийг олгохгүй, өргөдлийг хүлээн авч шийдвэрлэхгүй, хугацааг сунгахгүй байгаа- 20 маргаан
- Төрийн албан хаагчийг ажилд эгүүлэн тогтоосон шийдвэр гаргахгүй байгаа- 10 маргаан
- Бусад маргаан 9 байна. Бусад маргаан гэдэгт оюуны өмчийн улсын байцаагчийн акттай холбоотой маргаан, Нийслэлийн Засаг даргаас орон сууц, түрээсийн байрны хувьчлалын асуудлыг шийдвэрлэхгүй байгаа маргаан, хувьцаа, нийгмийн даатгал, нөхөн төлбөр, улсын бүртгэлтэй холбоотой маргаанууд хамаарч байна.

⁵⁵ Л.Өлзийжаргал. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хэрэгжилт, тулгамдсан асуудал. Шүүх эрх мэдэл эмхтгэл, 3-р улирал,

Иргэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас захиргааны актыг хүчингүй болгосон, захиргааны байгууллагаас зохих акт гаргахыг даалгасан, актын биелэлтийг түдгэлзүүлж, энэ хугацаанд дахин шинэ акт гаргахыг даалгасан шийдвэрээс гадна захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх арга хэмжээг авахуулахаар хандсан байна.

Шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтныг авч үзвэл:

- Нийслэлийн Засаг дарга -22 шийдвэр,
- Ашигт малтмалын газар, Геологи уул уурхайн кадастрын хэлтсийн дарга- 20 шийдвэр
- Дүүргийн Засаг дарга нар- 6 шийдвэр
- Улсын бүртгэлийн ерөнхий газар- 4 шийдвэр
- Төрийн нарийн бичгийн дарга-2 шийдвэр
- МХЕГ, НМХГ-3 шийдвэр
- Яам-1 шийдвэр
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл -1 шийдвэр
- Зэвсэгт хүчний жанжин штаб-1 шийдвэр
- Цагдаагийн ерөнхий газрын дарга-1 шийдвэр
- Татварын ерөнхий газрын дарга-1 шийдвэр
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга-1 шийдвэр
- Оюуны өмчийн газар-1 шийдвэр
- Санхүүгийн зохицуулах хороо-1 шийдвэр
- Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс -1 шийдвэрийг тус тус биелүүлээгүй байна.

Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар захиргааны байгууллага, албан тушаалтанд шийдвэр гүйцэтгэгчээс эрүүгийн хариуцлага ногдуулахаар дүүргийн цагдаагийн хэлтэст хандсан боловч хэрэг үүсгэхээс ор тас татгалздаг байна. Энэ нь сүүлийн 5 жилийн байдлаар 164 эрүүгийн хэрэг үүсгэх хүсэлт гаргаснаас 23 хэрэгсэхгүй болгосон, 140 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэсэн, 1 ял эдлүүлсэн⁵⁶ байх судалгаанаас харж болно.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан нөхцөл:

Захиргааны байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл өгөх, захиргааны, эрүүгийн хариуцлага тооцуулахаар холбогдох байгууллагад хүсэлт гаргах төдийхөнөөр албадлагын ажиллагаа явагдаж, улмаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд хариуцлага тооцсон асуудал туйлын хангалтгүй байгаа бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр авагчийн эрхийг сэргээн эдлүүлэх боломжгүй байдал үүсдэг.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйлд Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйлд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасны дагуу албадан гүйцэтгэнэ гэж заасан байдаг. Гэтэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэлд захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гэснээс өөрөөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд тусгайлсан зохицуулалт байхгүй.

⁵⁶ Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал-шинэчлэлийн хэрэгцээ, шаардлага. ШШГЕГ-ын дарга, Улсын ерөнхий гүйцэтгэгч, Хурандаа Д.Дамдинцэрэн, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл, Олон улсын эрдэм шинжилгээний хурал, ХЗЯам, 2014 он 9 сар

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлд шүүхээс гарах шийдвэрийн төрлийг нэг бүрчлэн зааж өгсөн. Тэдгээрээс захиргааны байгууллага албан тушаалтнаас иргэн хуулийн этгээдэд учруулсан хохиролыг гаргуулах, өөрчлөх мөнгөн дүнгээр илэрхийлэх тохиолдолд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтын хэрэглэх боломжтой. Харин маргаан бүхий захиргааны актыг яаж хүчингүй болгох яаж гүйцэтгэх тухай гүйцэтгэх хуудсанд тодорхой бус байдаг. Шүүхээс гарч буй шийдвэр хэрэгжих боломжтой түүнд хэрэгжүүлэх арга замыг тодорхой заах нь тухайн шийдвэр биелэгдэх анхдагч нөхцөл болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлохдоо иргэний болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага хэмээн заажээ. Харамсалтай нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан журамлаагүй, зохицуулалт дутуу байгаа энэ үед захиргааны байгууллага албан тушаалтанд тухайн шийдвэрийг биелүүлэх албадлага хэрэглэх боломж учир дутагдалтай байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг үл тоомсорлодог. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас дарамт шахалт ирдэг бөгөөд шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эрх зүйн хамгаалалт, чадамж муу байдаг.

Цаашид шүүхийн шинэтгэлийн хүрээнд зайлшгүй анхаарах ёстой асуудал нь шүүхийн шийдвэрийн биелэлт, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болсон нь гарцаагүй харагдаж байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий нэгжийн бүтэц тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, өнөөгийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаж дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна гэж үзэж байна.

Бусад

График 19.



Монгол Улсын арбитрын шүүхийн гүйцэтгэх хуудсаны гүйцэтгэл энэ оны 8 сарын байдлаар 12 гүйцэтгэх хуудсаас 2 нь бүрэн биелүүлсэн буюу 16.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Харин сүүлийн 3 жилээр харьцуулж үзвэл 2011 онд 8 гүйцэтгэх хуудсаас 5 бүрэн биелүүлсэн буюу 62.5 хувийн гүйцэтгэлтэй, 2012 онд 9 гүйцэтгэх хуудсаас 3 бүрэн биелүүлсэн буюу 33.3 хувийн гүйцэтгэлтэй, 2013 онд 13 гүйцэтгэх хуудсаас 7 бүрэн биелүүлсэн буюу 53.8 хувийн гүйцэтгэлтэй байна. /График 19/

Нотариатын мэдэгдэх хуудастай гүйцэтгэх хуудас 2010, 2011 онд бичигдээгүй бол 2012 онд 1 бичигдэж тэр нь биелээгүй, 2013 онд 6 гүйцэтгэх хуудсаас 5 бүрэн биелэж 83.3 хувийн гүйцэтгэлтэй байсан байна.

Гадаадын шүүх. Олон улсын арбитрын шийдвэртэй гүйцэтгэх хуудас 2010,2011 онуудад тус бүр нэг байгаад тэр нь биелээгүй бол 2012 онд 5 гүйцэтгэх хуудсаас 1 биелж 20 хувь гүйцэтгэлтэй , 2013 онд 4 гүйцэтгэх хуудсаас 1 биелж 25 хувийн гүйцэтгэлтэй байсан байна.⁵⁷

ХОЁР. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 1877 онд батлагдаж 1950, 1990 онуудад өөрчлөлт орсон Иргэний процессийн хуулийн 5 дугаар бүлэг 704-945 дугаар зүйлүүдэд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмыг зохицуулсан байдаг. Уг хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийтлэг үндэслэл, төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулах, хуулийн этгээдийн төлбөрийг төлүүлэх журам зэргийг тогтоож өгсөн бол тус хуулийн 166, 753, 808, 831 дүгээр зүйлүүдэд ба Шүүхийн байгууламжийн тухай хуулийн 154 дүгээр зүйлд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлжээ. Холбооны Бүгд Найрамдах Герман улсад шүүхийн шийдвэрийг 3-н хэлбэрээр гүйцэтгэдэг. Үл хөдлөх эд хөрөнгийг албадан хураан авах ажиллагаа эдийн засгийн хувьд хамгийн оновчтой ашигтай хүнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг бөгөөд энэ нь төлбөр төлөгчид хүнд тусдаг байна. Энэ аргыг 3-н тохиолдолд хэрэглэдэг.

1. Үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах
2. Төлбөр авагчид албадан шилжүүлж өгөх
3. Үл хөдлөх хөрөнгийг хурааж зээлээр худалдан борлуулах газарт шилжүүлж мөнгийг нь оруулах

Төлбөр авагчийн өргөдлийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийг хурааж шүүхийн шийдвэрийн дагуу худалдан борлуулдаг.Төлбөр авагчид төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг танилцуулсанаар төлбөр авагч өөрийн төлбөрөө бүрэн барагдуулах боломжтой зарагдах үл хөдлөх эд хөрөнгийг сонгоно. Үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах журам нь хөдлөх эд хөрөнгийг худалтахтай адил явагддаг. Үл хөдлөх эд хөрөнгийг хурааж авсаны дараа дуудлага худалдааг шүүхийн танхимд эсвэл тухайн шүүхийн тойрогт заасан байрлалд явуулна.

Дуудлага худалдаа явагдахаас зургаан долоо хоногийн өмнө дуудлага худалдаа явуулах тухай шүүхийн шийдвэр гарсан байх ёстой. Шүүхийн шийдвэрт:

- Дуудлага худалдаанд оруулах эд хөрөнгийн тухай
- Дуудлага худалдаа явагдах огноо, газар
- Дуудлага худалдаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар явагдаж байгаа гэдгийг заавал тусгасан байх ёстой.

⁵⁷Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн 2011,2012,2013 оны мэдээ

Үл хөдлөх эд хөрөнгө нь тухайн эд хөрөнгийн хамгийн доод үнээс багагүйгээр, бусдаас хамгийн өндөр үнэ амалсан этгээдэд худалдагдана. Хамгийн бага үнэлгээ нь төлбөр авагчийн шаардлагыг хангахуйц хэмжээнд байх ёстой. Дуудлага худалдаа дуусаад төлбөр авагч шаардлагатай хэмжээний төлбөрөө авсны дараа төлбөр авагчийн гомдол барагдаж төлбөр барагдсан тухай шүүхийн тогтоол гарна. Энэ тогтоолын үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэлийн газар бүртгэл хийх ажиллагаа явагдсаны дагуу төлбөр төлөгч үл хөдлөх эд хөрөнгө эзэмших эрхээ алдана.

Төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаа явуулахгүйгээр төлбөр авагчид шилжүүлэх ажиллагаа шүүхийн шийдвэрийн дагуу явагдана. Төлбөр авагч үл хөдлөх хөрөнгөө өөрөө биечлэн авах хүртэл төлбөр төлөгч чанар байдлыг нь муутгахгүйгээр зориулалтын дагуу ашиглаж болдог. Хэрхэн ашиглаж байгаад нь шийдвэр гүйцэтгэгч хяналт тавина.

Төлбөр төлөгч төлбөрөө төлөх ямар ч боломжгүй, эд хөрөнгөгүй тохиолдолд шүүхээс түүнд итгэл үзүүлэх буюу тангараг өргүүлэх замаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх төрөл байдаг. Энэ тохиолдолд төлбөр төлөгч төлбөрийг хэсэгчлэн төлдөг бөгөөд шүүхийн шийдвэр биелэгдсэн гэж үздэг байна. ХБНГУ-д үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдагдаж байгаа тохиолдолд хэзээ ч зах зээлийн үнээр зарагдаггүй. Тухайн эд хөрөнгийг доод тал нь 30 хувиас доош үнээр хүмүүс авдаг байна. Төлбөр төлөгчийн төлбөр нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн үнийн 7 хувиас дээш байх ёстой. Энэ тохиолдолд дуудлага худалдаагаар худалдах 7 хувиас доош үнэтэй байвал дуудлага худалдаагаар заавал худалдаалахгүй.

ХБНГУ-д дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулдаг бөгөөд энэ арга нь бусад байгууллага болон албан тушаалтны нөлөөлөлд автахгүй сайн талтай байдаг байна. Хууль зүйн яамны харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сайт дээр дуудлага худалдаа зарлагдана. Дуудлага худалдаанд оролцохын тулд гарааны үнийн 5 хувийг пластик картаар төлж кассанд байршуулна. Мөнгөө төлж бүртгүүлсний дараа дуудлага худалдаанд оролцогчийн үнэмлэх авна. Хэрэв дуудлага худалдаанд ялсан тохиолдолд 3 хоногийн дотор үлдсэн бүх мөнгийг төлөх ёстой. Албадан цахим дуудлага худалдаа явуулах хугацаа нь 10 хоног байна. Хугацаа дуусаад 10 минут өнгөрөхөөс өмнө дахин өндөр үнийн санал орж ирсэн тохиолдолд дахин 10 минутаар сунгагдах зарчмаар явагддаг байна. Цахим хэлбэрээр дуудлага худалдаа явуулж буй Герман улсын туршлага нь дуудлага худалдааг нээлттэй, ямар нэгэн хээл хахууль зэргээс хамгаалж чадаж буй сайн туршлага юм.⁵⁸

2.2. Бүгд Найрамдах Солонгос Улс

Дэлхийн банкнаас гаргасан бизнесийн эрх зүйн орчны судалгаанаас /Doing business 2013/ үзвэл БНСУ нь гэрээний гүйцэтгэл-ийн /Enforcing contracts/ үр дүнгийн үзүүлэлтээр дэлхийд 2-т үнэлэгдэж байна.⁵⁹

БНСУ-д Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн ажиллагаа нь хуучин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн

⁵⁸ Э.Нармандах “Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” <http://issuu.com/oyunsanaasanaa/docs/narmandah>

⁵⁹ Жун Жай Хун “БНСУ-ын шийдвэр гүйцэтгэх эрх зүй” илтгэл Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл Олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2014 он

шийдвэрийг албадан гүйцэтгэх гэсэн 7-р бүлгээр зохицуулагдаж байсан байна. 2002 онд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай бие даасан “Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай”/ Civil execution act/ хуулийг баталж хэрэгжүүлж эхэлжээ. Уг хуулиар шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагаа, барьцааны эрхийг хэрэгжүүлэх дуудлага худалдаа, Иргэний хууль, Худалдааны хууль, бусад хуулийн дагуу явуулах дуудлага худалдааны горим буюу иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон холбогдох хамгаалалтын арга хэмжээний горим, журмыг зохицуулдаг байна.

БНСУ-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэлийн шүүх хэрэгжүүлдэг байна. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 3 дугаар зүйлд: Энэ хуульд заасан гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг харъяалж буй эсхүл эдгээр ажиллагааг бусад шүүхтэй хамтран ажиллах ажиллагааны дагуу харъяалж буй гүйцэтгэлийн шүүх нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гүйцэтгэлийн ажиллагааг явуулах газар болон этгээдийг харъяалах дүүргийн шүүх байна. Гүйцэтгэлийн шүүхийн шийдвэрт гаргасан аливаа гомдлыг үл харгалзан түүнийг гүйцэтгэж болно.⁶⁰

БНСУ-д шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр гаргуулах ажиллагаа, мөнгөн төлбөр гаргуулах ажиллагаа гэж хоёр ангилдаг. Төлбөр гаргуулах ажиллагаанд үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгө, шаардах эрхээс төлбөр гаргуулан мөнгөн хөрөнгө болгох үйл ажиллагааг хэлдэг. Мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг төлбөр төлөгчийн эзэмшлээс хураан авч төлбөр авагчид шилжүүлэх буюу эд хөрөнгийг шилжүүлэх шаардлага, төлбөр төлөгчийн тодорхой үйлдэл хийх, тодорхой үйлдэл хийхгүй байх эрхийг шууд бус албадлагын арга хэмжээгээр хэрэгжүүлдэг байна. БНСУ-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх гэж тусдаа шүүх байдаг. БНСУ-ын шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл, бичиг баримтын хүргэлт зэрэг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг бие даасан хуулийн байгууллага юм. Шийдвэр гүйцэтгэх байгууллага нь зөвхөн шүүх ба шүүгчдэд туслах чанарын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага биш, өөрийн хариуцлагын хүрээнд бие даан төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага байдаг байна. Шийдвэр гүйцэтгэгчээр 10 жилээс дээш хугацаагаар шүүх, прокурорын ажилтнаар ажиллаж байсан хүмүүсээс харьяалах орон нутгийн шүүхийн Ерөнхий шүүгч сонгон томилдог бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн тэтгэвэрт гарах нас 61, бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байдаг.⁶¹

Төлбөр гаргуулах ажиллагаа:

Төлбөр авагч өөрөө аль эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулахыг сонгодог. Төлбөр авагчийн энэ үүрэг эрхийг хангахын тулд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад/туслах/ арга хэмжээг хуульчлан тогтоосон байдаг.

Үүнд дараах арга хэмжээ ордог:

- Төлбөр авагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүхэд төлбөр төлөгчийн эд хөрөнгийн мэдүүлгийг гаргаж өгөх хүсэлтийг гаргана. Шийдвэр гүйцэтгэх шүүх хүсэлтийг хүлээн аваад төлбөр төлөгчид өөрийн бүхий л хөрөнгийн мэдээллийг үнэн зөвөөр гаргаж өгөхийг даалгасан шийдвэр гаргадаг. Энэ шийдвэрийг

⁶⁰ БНСУ-ын Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 3 дугаар зүйл, 2002 он

⁶¹ Жун Жай Хун “БНСУ-ын шийдвэр гүйцэтгэх эрх зүй” илтгэл Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл Олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2014 он

хүлээж авсан төлбөр төлөгч нь шүүхийн товлосон өдөр өөрийн эд хөрөнгийн жагсаалтыг үнэн зөвөөр гаргаж өгөхөөс гадна эд хөрөнгийн жагсаалт нь үнэн зөв гэдгийг шүүхийн өмнө батлан тангарагладаг. Эд хөрөнгийн мэдүүлэг авах энэ арга нь ХБНГУ-ын эд хөрөнгийн мэдүүлэг авах ажиллагаатай төстэй юм. Хэрэв төлбөр төлөгч шүүхээс товлосон хугацаанд эд хөрөнгийн мэдүүлгээ гаргаагүй тохиолдолд дээд тал нь 1 сар хүртэлх хугацаагаар саатуулан хорьдог. Эд хөрөнгийн мэдүүлгийг хугацаанд нь гаргаж өгсөн боловч өөрийн гол эд хөрөнгийг орхигдуулсан, эсвэл худал мэдүүлэг өгсөн тохиолдолд мөн адил арга хэмжээ авагддаг. Эд хөрөнгийн мэдүүлгийг үнэн зөвөөр гаргасан боловч тухайн эд хөрөнгийн жагсаалтад нэхэмжлэлийн шаардлага хангах эд хөрөнгө байхгүй байгаа тохиолдолд өртэй этгээдийн бүртгэлд төлбөр төлөгчийг бүртгэдэг бөгөөд энэ бүртгэлийг бүх ард иргэдэд интернэтээр мэдээлдэг байна. Энэхүү мэдээлэл ил болсоны дараа тухайн төлбөр төлөгч нийгэмд дахин эдийн засгийн үйл ажиллагаа хийхэд хүндрэлтэй болдог.

- Тухайн хүний эд хөрөнгийн мэдээллийг олж авах арга хэмжээг хэрэгжүүлж болдог. Эд хөрөнгийн мэдүүлгийг авсаны дараа хангалттай биш, эсвэл нэмж ажиллагаа явуулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эд хөрөнгийг нь судлан тогтоох мэдээллийг олж авах лавлагаа гаргуулах ажиллагааг эхлүүлдэг байна.
- Банкны дансны мэдээлэл олж авах нь дээрх ажиллагааны нэг хэсэг юм. Төлбөр авагч шийдвэр гүйцэтгэх шүүхэд хүсэлт гаргах бөгөөд шүүхээс хүсэлтийг хангуулах шийдвэр захирамж гарсаны үндсэн дээр энэ ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой. Үл хөдлөх хөрөнгө зэрэг үнэлгээ өндөртэй хөрөнгийн лавлагааг ихэвчлэн Улсын үндэсний татварын газраар дамжуулан мэдээллийг авдаг байна. Үнэт цаасны эрх болон бусад шаардах эрхийн тухай мэдээллийг зөвхөн банкнаас болон бусад санхүүгийн байгууллагаас гарган авах боломжтой. БНСУ-д банкны бүх мэдээлэл, банкны дансны мэдээлэл зэрэг нь “Санхүүгийн зохицуулах хороо”-той төстэй хяналтын үүрэг гүйцэтгэдэг байгууллагад төвлөрч байдаг. Түүнчлэн иргэдийн үнэт цаасны эрх болон гадаад дах дансны мэдээлэл уг байгууллагад төвлөрч байдаг байна. Эд хөрөнгө болон, банкны дансны мэдээлэл авахуулах шийдвэр гаргасан шүүх нь банк тус бүрт лавлагаа ав ахуулах хүсэлт явуулдаггүй харин энэ мэдээллийг нэгтгэн удирдаж байдаг “Санхүүгийн байгууллагын холбоо”-нд хандаж тухайн төлбөр төлөгчийн мэдээллийг гаргуулах даалгавар явуулдаг байна. Шүүхийн шийдвэрийг хүлээн авсан тухайн байгууллага нь интернетийн нэгдсэн сүлжээг ашиглан өөрсдийн гаргаж болох мэдээллийг хайж гаргаж өгдөг. БНСУ-д санхүүгийн болон данстай холбоотой мэдээллийг авах ажиллагааг тухайн хүний дансны мэдээллийг цахим орчноор дамжуулан авдаг байна. Лавлагааг буруу зорилгоор ашиглан хувь хүний нууцтай холбоотой асуудал гардаг учраас банкны лавлагаа гаргуулахаар тавьсан хүсэлтэд өндөр шаардлага тавьдаг. Зөвхөн шүүхийн шийдвэр гаргуулсан төлбөр авагч энэ хүсэлтийг авах эрхтэй байдаг. Энэ ажиллагааны өмнө төлбөр төлөгчийн эд хөрөнгийн мэдүүлэг авах ажиллагаа заавал хийгдсэн байх ёстой. Эд хөрөнгийн мэдүүлэг эргэлзээтэй, эсвэл гаргасан эд хөрөнгийн үнэ нь нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд данснаас лавлагаа гаргах арга хэмжээг авдаг байна. Дансны мэдээлэл гаргаж өгөх үлдэгдэл хэмжээ нь 500.000 воноос дээш байх хязгаарлалт гаргаж өгсөн байдаг. Дансны мэдээлэл авах хүсэлтийн тэмдэгтийн хураамж нь 5 доллар орчим байдаг. Шүүх төлбөр төлөгчийн дансны мэдээллийн лавлагааг 3 долоо хоногийн

дотор гаргаж өгөх хугацаа заадаг байна. Тухайн төлбөр төлөгч нэг банканд данстай тохиолдолд зөвхөн тэр банк уруу шийдвэрээ явуулдаг олон банканд данстай тохиолдолд Санхүүгийн холбоо руу явуулдаг байна. Энэхүү мэдээллийг маш хатуу хяналт шалгалтын дор ашигладаг. Мэдээллийг гаргуулах хүсэлт гаргасан төлбөр авагч нь дансны мэдээлэлтэй танилцаж үзсэний үндсэн дээр данснаас төлбөр гаргуулах хүсэлтээ явуулдаг байна. Түүнчлэн тухайн төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах боломжтой бусад төлбөр авагчид дансны мэдээлэлтэй танилцах боломжтой. Банкны данснаас төлбөр гаргуулах энэ ажиллагааг БНСУ-д шийдвэр гүйцэтгэх ажиллагааны туслах арга хэмжээ гэж үздэг. Энэ нь хувь хүний мэдээлэл нууцтай холбоотой асуудал учраас, дансны мэдээлэл авахтай холбоотой хатуу санкцуудыг хэрэглэдэг. Дансны лавлагаа гаргаж өгөхгүй байгаа банк болон санхүүгийн холбооны ажилтанд 5 сая воны торгууль оногдуулдаг байна. Дансны мэдээллийг өөр зорилгоор ашигласан тохиолдолд 2 жил хүртэлх албадан ажил хийлгэх шийтгэл 5 сая хүртэлх воны торгууль оногдуулдаг байна.⁶²

БНСУ-д хэрэгжүүлж буй дээрх туслах арга хэмжээ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үр нөлөөтэй нь харагдаж байгаа бөгөөд Монгол улсад энэ талаарх зохицуулалт дутмаг байна.

БНСУ-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлбөр авагч урьдчилан төлдөг. Шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрөөс санхүүжилт авдаггүй хувь хүний итгэмжлэл, төрийн байгууллага, шүүх, прокурорын байгууллагын шийдвэрийг үндэслэн ажиллагаа явуулсан шийдвэр гүйцэтгэлийн хэргээсээ хуулиар тогтоосон хураамж авдаг. Үүнд:

- Бичиг баримтын хүргэлтийн хураамж нь 1 удаа 1000 вон амралтын өдөр оройн цагаар 1500 вон
- Худалдан борлуулсны хураамж – худалдан борлуулсан үнийг жишиг болгодог. 1-100,000 вон 5000
- 100,000-10 сая вон 100,000 вон тутамд 2000 вон нэмэгдэнэ
- 10 сая-50сая 100,000 вонд 1500 вон нэмэгдэнэ гэх мэт.

БНСУ-д захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлэхгүй байгаа тохиолдолд шаардлагатай гэж үзвэл шийдвэр гүйцэтгэх шүүхээс шийдвэр биелүүлэх хугацаа тогтоодог бөгөөд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй өдөр тутамд 1 сая воны торгууль төлөх шийдвэр гаргадаг байна. Хугацаа өнгөрөх тусам торгуулийн хэмжээ нэмэгддэг. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй бол торгуулийн хэмжээ нь зогсоно гэсэн ойлголт байдаггүй учраас төрийн байгууллагад шүүхийн шийдвэрийг яаралтай биелүүлэх шаардлага тавигддаг байна. Иймээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэр гарсан бол нэн даруй биелүүлдэг байна.

⁶²Жун Жай Хун “БНСУ-ын шийдвэр гүйцэтгэх эрх зүй” илтгэл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл Олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2014 он

ДҮГНЭЛТ

Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсөн хэн боловч шүүхэд гомдол, нэхэмжлэл гарган зөрчигдсэн эрхээ сэргээлгэн шийдвэр, магадлал, тогтоол гаргуулдаг. Энэхүү гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг сайн дурын үндсэн дээр биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа хийгддэг бөгөөд ИХШХШТХ-ийн 18 дугаар бүлэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэлийн албадах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тодорхойлсон.

Өнөөдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилт ямар түвшинд байгааг хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын гүйцэтгэх ажиллагаа, иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагаа, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагаа гэсэн бүтэцтэйгээр судлахыг зорьсон.

Нэгдүгээрт, Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын гүйцэтгэх ажиллагаа

Монгол улсад одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулиар торгох, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа хасах ялыг хорихоос өөр төрлийн ялын төрөлд хамааруулж байгаа боловч үүнийг хэрэгжүүлж байгаа арга хэлбэр тодорхой бус нарийвчилсан хуулийн зохицуулалтгүй, иргэний шийдвэр гүйцэтгэлтэй хавсран ялын хэрэгжилтийг хангаж байгаа тул энэ төрлийн ялын ач холбогдол төдийлөн ялгарч харагддаггүй байна.

Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлууд гарсаар байна. Тухайлбал, Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-д эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан болон эд хөрөнгө, зардал гаргуулах, хохирол төлүүлэх заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас гэж заасан бөгөөд “тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шийтгэх тогтоолд” зарим шүүгч гүйцэтгэх хуудас бичихгүй байгаагаас ялтан хяналтанд бүрэн хамрагдахгүй байна⁶³. Мөн торгох ялыг шүүхээс төлбөрийн чадваргүй, амжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой, оршин суух хаяггүй хүнд оногдуулдаг нь уг ялын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй бөгөөд түүнчлэн ялтан хуулийн алдаатай хийдлийг ашиглан график гарган, бага хэмжээгээр төлбөрөө төлөн гүйцэтгэлийг удаашруулан ял завших оролдлого хийдэг байна⁶⁴. Эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заахаар хуульчилсан боловч практикт ихэвчлэн мөнгөн хэлбэрээр оногдуулдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94.1 зааснаар Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг, эд хөрөнгө дансалсан буюу битүүмжилсэн актын хамтаар ялтны эд хөрөнгө байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд шүүх 3 хоногийн дотор хүргүүлнэ гэсэн заалт бүрэн хэрэгждэггүй, хорих ял дээр эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулсан гүйцэтгэх хуудас бүрэн бичигдэж ирдэггүй байна. Албадан ажил хийлгэх ялын тухайд, Эрүүгийн хууль, Шүүхийн

⁶³ Н.Отгонбаяр. “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зарим асуудал” илтгэл. Улаанбаатар, 2014 он.

⁶⁴ Л.Алтансүх. “Ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт, тулгамдсан асуудал” Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл, 2013 он, №02, 10 дахь тал.

шийдвэр гүйцэтгэх тухай хуульд уг ялыг хаана, ямар байгууллагад ажиллуулах нь тодорхой бус зөрчилтэй байна. Практикт аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга ажлын байраар хангах идэвхи сул, шийдвэр гүйцэтгэгчээс түүнд өдөр тутам биечлэн болон цаг ашиглалтанд хяналт бүрэн тавьж чаддаггүй, өнөөдрийн нөхцөлд хаана, ямар төрлийн ажил хийлгэх нь тодорхой бус байгаа юм⁶⁵.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулсан тохиолдолд шүүхээс гүйцэтгэх хуудсыг харьяа шийдвэр гүйцэтгэх албанд харилцан адилгүй бичиж ирүүлж байна.

Хоёрдугаарт, Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагаа:

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн төлбөр төлөгчийн төлбөрийн чадвараас шууд шалтгаалдаг бөгөөд нэхэмжлэгчээс эд хөрөнгийг шүүхийн шатанд хамгаалуулах арга хэмжээг авхуулаагүйгээс төлбөр төлөгч эд хөрөнгөө нуух, бусдад шилжүүлж үрэгдүүлсэнээс төлбөрт гаргуулах эд хөрөнгө тогтоогдохгүй байх, төлбөрөөс зайлсхийдэг, салбар хуулиуд, хуулийн бусад байгууллагын хамтын ажиллагаа уялдаа холбоо хангалтгүй, захиргааны байгууллага албан тушаалтан шүүхийн шийдвэр биелүүлдэггүй, биелүүлэхээс зайлсхийдэг зэрэг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах томоохон шалтгаан болж байна. Мөн энэ чиг үүргийг гүйцэтгэж буй шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал тэдний ажиллах орчин, нийгэм эдийн засгийн баталгаа хангалтгүй байна. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь өмнө дагаж мөрдөж байсан хуулиудаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааг илүү нарийвчилсан хэдий ч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практикт хэрэглэхэд ялангуяа, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал урамшуулал, хүүхдийн тэтгэлгийн төлбөр гаргуулах, үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагаанд бэрхшээл тулгарч байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 12 жилийн хугацаанд иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй холбоотой 279847 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулан явуулсан байна. Нийт гүйцэтгэх баримт бичгийн буюу 80.8 хувь нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр байна.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 27716 гүйцэтгэх баримт бичиг байгаагийн 72.3 хувь нь иргэнд олгох, 27.7 хувь нь хуулийн этгээдэд олгох төлбөр байгаа ба нийт мөнгөн дүнгийн 75.5 хувь нь өндөр үнийн дүнтэй /100 саяаас дээш/ гүйцэтгэх бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.⁶⁶

Гурвдугаарт, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2010 оноос улсын хэмжээнд захиргааны шүүхийн шийдвэртэй гүйцэтгэх хуудсын бүртгэл хөтөлдөг болсон байна. Энэ 5 жилийн хугацаанд 413 захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй хуудас шүүхээс ирснээс 298 буюу 72.1 хувийг бүрэн гүйцэтгэсэн байна. Тодруулбал 4 гүйцэтгэх хуудас тутмын 1 нь биелээгүй байна. Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар захиргааны байгууллага,

⁶⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. “Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2014 он, 23 дахь тал.

⁶⁶ Д. Дамдинцэрэн “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал шинэчлэлийн хэрэгцээ, шаардлага” илтгэл 2014 он

албан тушаалтанд шийдвэр гүйцэтгэгчээс эрүүгийн хариуцлага ногдуулахаар дүүргийн цагдаагийн хэлтэст хандсан боловч хэрэг үүсгэхээс ор тас татгалздаг байна. Энэ нь сүүлийн 5 жилийн байдлаар 164 эрүүгийн хэрэг үүсгэх хүсэлт гаргаснаас 23 хэрэгсэхгүй болгосон, 140 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэсэн, 1 ял эдлүүлсэн⁶⁷ байх судалгаанаас харж болно.

Захиргааны байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл өгөх, захиргааны, эрүүгийн хариуцлага тооцуулахаар холбогдох байгууллагад хүсэлт гаргах төдийхөнөөр албадлагын ажиллагаа явагдаж, улмаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд хариуцлага тооцсон асуудал туйлын хангалтгүй байгаа бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр авагчийн эрхийг сэргээн эдлүүлэх боломжгүй байдал үүсдэг. Гэтэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэлд захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гэснээс өөрөөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд тусгайлсан зохицуулалт байхгүй. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан журамлаагүй, зохицуулалт дутуу байгаа энэ үед захиргааны байгууллага албан тушаалтанд тухайн шийдвэрийг биелүүлэх албадлага хэрэглэх боломж учир дутагдалтай байна. Тиймээс захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг үл тоомсорлодог. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас дарамт шахалт ирдэг бөгөөд шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эрх зүйн хамгаалалт, чадамж муу байдаг.

Эцэст нь дүгнэхэд дараах хэдэн бодлогын хувилбаруудыг санал болгож байна.

Үүнд:

- 1) Монгол улсын шүүхээс сүүлийн гурван жилд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн статистик мэдээнээс үзвэл нийт ял шийтгүүлсэн хүмүүсийн 77 орчим хувь нь хорих ял шийтгүүлсэн бөгөөд үлдсэн 23 хувь нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл дөрвөн хүн тутмын гурав нь хорих ял эдэлж байна. Хорих ял эдлүүлэх нь нийгэмд эерэг үр нөлөө багатай бөгөөд эдийн засгийн хувьд зардал ихтэй, Монгол дахь шоронгийн нөхцөл олон улсын шаардлагад нийцээгүй, шоронд удаан хугацаагаар хоригдсоноос нийгэмд дасан зохицох чадвар муу болдог байна. Хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн их байдаггүй тул дэлхий нийтэд хорихоос өөр төрлийн ялын бодлогыг баримтлах хандлагатай байна. Монгол улсад ч хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оногдуулдаг болох эрх зүйн орчин бүрдүүлэх, улмаар оногдуулсан хорих ялыг үр нөлөөтэй хэрэгжүүлдэг болох шинэчлэлийн бодлого явуулах шаардлагатай байна. Тухайлбал, Торгох ялын хэрэгжилтийг сайжруулахад эрх зүйн орчныг чангатгах, торгох ялыг хорихоос өөр бусад төрлийн ялаар сольж хохирлыг нөхөн төлүүлдэг тогтолцоонд шилжих нь илүү үр дүнтэй байж болох юм. Засаг даргын зүгээс албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах ажлын байрны жагсаалтыг шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлж байх хуулийн зохицуулалттай болох шаардлагатай байна. Учир нь шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шалтгаалахгүйгээр ажлын байрны тодорхой бус байдлаас уг ялын хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна. Хорих болон баривчлах ял дээр тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх

⁶⁷ Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал-шинэчлэлийн хэрэгцээ, шаардлага. ШШГЕГ-ын дарга, Улсын ерөнхий гүйцэтгэгч, Хурандаа Д.Дамдинцэрэн, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл, Олон улсын эрдэм шинжилгээний хурал, ХЗЯам, 2014 он 9 сар

хасах ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол гүйцэтгэх баримт бичгийг шийтгэх тогтоолын хамт эсвэл ял эхлэх тоолох үед бичиж ирүүлэх асуудлыг нэг мөр болгож шийдвэрлэх шаардлагатай юм.

Дэлхийн улс орнуудад аль болох хорихоос өөр төрлийн ялыг оногдуулах, гэмт хэрэгт тохирсон хорихоос өөр төрлийн ялыг оногдуулж, тухайн ялтныг нийгэм, хамт олонд нь байлгаж, учирсан хор хохирлыг арилгуулах, гэмт хэрэг үйлдэхгүй байхыг ухамсарлуулах арга хэмжээ авдаг байна. Ингэхдээ гэмт хэрэгтнийг хянах, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тухайн хэрэгтэнд цахилгаан бугуйвч, суурин болон хөдөлгөөнт телекамер, байрлал тогтоогч “GPS” төхөөрөмж ашиглах зэргээр хяналт тавьдаг байна.

- 2) Төлбөр төлөгч хуулийн этгээдийн гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс, хэрэг гүйцэтгэгчид шилжүүлсэн ч төлбөрийг барагдуулах ажиллагаанд хяналт тавих, төлбөрийг хэрхэн барагдуулж байгаа талаар мэдээлэл авах, төлбөрийг бүрэн гүйцэтгэсэн талаар мэдээлэл авсан тухай бүр нь гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухайн шийдвэр гаргах, татан буулгах комисс болон хэрэг гүйцэтгэгчийн буруу үйл ажиллагааны талаар гомдол гаргах эрхийг шийдвэр гүйцэтгэгчид олгох.
- 3) Шүүхийн шийдвэрийн биелэлт, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болсон нь гарцаагүй харагдаж байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий нэгжийн бүтэц тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, өнөөгийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаж дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна гэж үзэж байна.

Санал зөвлөмж

- 1) Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулж буй төлбөр төлөгчид хариуцлага тооцох албадлагын нөлөөллийн арга хэмжээг бий болгох
- 2) Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн хүчин төгөлдөр гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн бусдын өмчлөх эрхэнд халдах онцгой эрхийг хэрэгжүүлдэг учраас тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлж, мэргэшүүлэх, мэргэжлийн болон ёс зүйн өндөр соёлтой байх шаардлага тавих
- 3) Шийдвэр гүйцэтгэгчийн ажиллах орчинг сайжруулах, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангаж, тэдний тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх, албан үүргээ гүйцэтгэх явцад тулгарч байгаа хууль бус үйлдэл үйл ажиллагаанаас хамгаалах үйл ажиллагаанд хөндлөнгөөс бусад этгээд оролцохгүй байх, тэдний хууль ёсны шаардлага заавал биелэгдэх хууль зүйн үр дагаврыг бий болгох ажлын онцлогт тохирсон нийгэм эдийн засгийн баталгааг бүрдүүлэх шаардлага үүсээд байна.
- 4) Шийдвэр гүйцэтгэгчийг мэргэжлийн удирдалгаар хангах үүргийг шүүх гүйцэтгэж байхаар бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож зарчмын хувьд ял эдлүүлэх байгууллагаас салгах, цаашид төсөв санхүүгийн хувьд бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх үүднээс хувийн хэвшилд ажиллагаа явуулах эрх олгох боломжийг судлан хуульчлах нь зүйтэй.
- 5) Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрх зүйн зохицуулалт тусгагдсан боловч шүүхийн шийдвэрийн эцсийн үр дүнг шийдвэрлүүлэх боломж нөхцөл бүрдэхгүй байгааг анхаарч нэмэлт байдлаар эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх

- 6) Тэтгэлэг төлөгч тодорхой эрхэлсэн ажилгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэлтийн төвд бүртгүүлэх ажиллагааг явуулдаг болох мөн тухайн төлбөр төлөгчийг мэргэжлийн сургалтанд хамруулах, ажлын байраар хангах зэрэг ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна.
- 7) Албадан дуудлага худалдаанд оруулах үнийг оролцогчид харилцан тохиролцон тогтоохоор хуульчилсан байдаг. Гэтэл зарим төлбөр төлөгч нар үнийн санал өгөхөөс санаатайгаар зайлсхийж, шинжээчийн үнэлгээнд гомдол гарган шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд чирэгдэл учруулдаг. Төлбөр төлөгч, төлбөр авагч нар заавал харилцан тохиролцож албадан дуудлага худалдаанд оруулах үнийг тогтооно. Хэрэв тохиролцохгүй бол хөндлөнгийн шинжээчийг томилно. Хөндлөнгийг шинжээчийн тогтоосон үнэлгээнд гомдол гаргах эрхгүй байхаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.
- 8) Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэж болох заалтыг баримтлан “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хуулийн холбогдох зүйл, заалтыг удирдлага болгон албадан дуудлага худалдааг явуулах.
- 9) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан “сүүлийн үнэ хэлэхийг зарласан үе сүүлийн үнийн санал хоёрын хооронд 30 минут байх” гэсэн заалтыг хасах эсхүл хугацааг богиносгохоор өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
- 10) Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түргэн, шуурхай, нээлттэй явуулхад мөрдөх хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэхэд ойлгомжтой, ямар хугацаанд ямар арга, журмаар хэрхэн биелүүлэхийг хуулинд тодорхой тусгах.
- 11) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, тогтолцоог өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж өөрчлөх: Үүнд:
 - Иргэний хэргийн шүүхийн шийдвэр хэрэгжүүлэх ажиллагааг хувийн байгууллага, товчоо гүйцэтгэх
 - Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр болон хорихоос өөр төрлийн ял хэрэгжүүлэх ажиллагааг төрийн байгууллага гүйцэтгэх
 - Хорихоос өөр төрлийн ялын хууль эрх зүйн болон практик хэрэгжилтийг хангах механизмыг боловсронгуй болгох
- 12) Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулж саад учруулж буй төлбөр төлөгч болон захиргааны байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох албадлагын нөлөөллийн арга хэмжээг бий болгох.
- 13) Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн тогтолцоог хуульчлан тогтоох.
- 14) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшуулалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг оруулахгүй байхаар хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүрийг үнэлгээжүүлэх буюу ажиллагаа тус бүрт нийцсэн хураамжтай болох, үйлчилгээ хураамжийн хэмжээг хуулинд тодорхой заах; салбар хуулийн зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах; төрийн байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогддог болгох.

НОМ ЗҮЙ

Нэг. Хууль, Дээд шүүхийн тогтоол, эмхэтгэл, судалгаа

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
3. Монгол улсын Криминологийн судалгааны сектор. 2005 он
4. Улсын Дээд Шүүхийн 2003 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоол
5. Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйл.1948.12.10
6. Шүүхийн судалгаа мэдээлэл сургалтын хүрээлэн, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэгч нараас авсан социологийн судалгаа. 2014 он.
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдээ /2011-2013 он/
8. Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн статистик мэдээ, 2011, 2012, 2013 он.
9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. “Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2014 он, 8 дахь тал.
10. БНСУ-ын Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002 он
11. ХБНГУ-ын Иргэний процессын тухай хууль, 1877 он

Хоёр. Ном, сэтгүүл, илтгэл

1. А. Лхагваа Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл сэтгүүл (2012)№1
2. А.Лхагваа “Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2004 он
3. Б.Нямгомбо. “Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага” илтгэл, Улаанбаатар, 2013 он.
4. Д. Дамдинцэрэн “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал шинэчлэлийн хэрэгцээ, шаардлага” илтгэл 2014 он
5. Д.Зүмбэрэллхам, “Хорихоос өөр төрлийн ял болон хорих ялын альтернатив” илтгэл 2009 он.
6. Л.Алтансүх. “Ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт, тулгамдсан асуудал” Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл, 2013 он, №02.
7. Л.Өлзийжаргал. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хэрэгжилт, тулгамдсан асуудал.Шүүх эрх мэдэл эмхтгэл, 3-р улирал,
8. Н.Отгонбаяр. “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зарим асуудал” илтгэл. Улаанбаатар, 2014 он.

9. Тэгшжаргал “Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй зарим асуудал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох” илтгэл 2010 он
10. Ш.Энхжаргал “Үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” илтгэл 2013 он
11. Я.Батгэрэл “Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, анхаарах асуудал” илтгэл 2014 он

Гурав. Цахим холбоос

1. <http://ncs.cd.gov.mn/index.php/2013-08-23-08-58-31/2013-08-23-09-00-07>
2. <http://www.criminology.mn/index.php?option=newsm&id=160&lang=1>
3. <http://issuu.com/oyunsanaasanaa/docs/narmandah>
4. <http://www.gesetze-im-internet.de/bundesrecht/zpo/gesamt.pdf>
5. <http://www.moleg.go.kr/english/korLawEng?pstSeq=52691>
6. <http://cd.gov.mn/>



ХАВСРАЛТ

/Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдээс авсан анкетын судалгаа/

1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийн хэсэг

Бодлогын судалгааны хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын төлөөллөөс шүүхийн шийдвэр биелүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодруулах зорилгоор Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны нийт 66 ажилтнаас санал асуулга авлаа. Уг Судалгаанд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нийт 59 шийдвэр гүйцэтгэгч, 5 эрэн сурвалжлах ажилтан, 2 захиргааны ажилтан хамрагдсан /График №1/ бөгөөд 23 буюу 35 хувь нь эрэгтэй, 43 буюу 65 хувь нь эмэгтэй байна. /График №2/

График №1.



График №2.





График №3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд аль зарчим алдагдаж байна вэ? (Хувиар)



Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн 70 орчим хувь нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчмуудаас аль нэг нь алдагдаж, биелэгдэхгүй байна гэж үзсэн бол 30 гаруй хувь нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд аль нэг зарчим алдагдаагүй гэж дүгнэжээ. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дээрх зарчмуудаас хамгийн ихээр шуурхай байх зарчим, хуулийг дээдлэх зарчим (22.8%) алдагдаж байна гэж үзсэн байна.

График №4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг та хэрхэн үнэлдэг вэ?




2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ерөнхий чиг үүргийг биелүүлэхэд хангалтгүй, зохицуулалт дутуу байна гэж нийт асуулгад оролцсон шийдвэр гүйцэтгэгч нарын 98.5 хувь дүгнэсэн нь уг хуулийг өөрчлөн сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 2002 онд батлагдсанаасаа хойш 7 удаа өөрчлөлт орсон боловч түүнээс хойш 2002 онд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдаж 2004 оноос дагаж мөрдсөн тул энэ төрлийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа зохицуулалтгүй үлдсэн байна.

Шийдвэр гүйцэтгэгч нарын дурьдсан өөрчлөх шаардлагатай хуулийн зүйл заалтын санал⁶⁸

- + Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэхгүй байгаа тохиолдолд цагдан хорих болон хариуцлага тооцдог зүйл заалттай болох-10
- + Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Албадан дуудлага худалдаа явуулахтай холбоотой зүйл заалтууд-9
- + Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гомдол гаргах, гомдол гаргах хугацаатай заалтууд-6
- + Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Түр саатуулах шийдвэр, түүнийг гүйцэтгэх заалтыг сэргээх-2

График №5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль бусад хууль, тогтоомжуудтай хэр уялдаж байна вэ?




Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийн уялдааг шийдвэр гүйцэтгэгчдийн 82 хувь нь тодорхой хэмжээгээр уялддаг, 14.8 хувь нь бүхэлдээ зөрчилддөг гэсэн бол 3.3 хувь нь огт зөрчилддөггүй гэж тодорхойлсон байна.

Ямар хуулийн аль зүйл заалттай зөрчилддөг талаар⁶⁹

⁶⁸Нээлттэй асуулга №5

- ✚ Банкны тухай хууль, Дансны мэдээлэл авахтай холбоотой зүйл заалтууд-18
- ✚ Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэхтэй холбоотой зүйл заалтууд-7
- ✚ Цагдаагийн албаны тухай хууль, Хамтарч ажиллах тухай холбоотой зүйл заалтууд -5
- ✚ Иргэний хууль, 175, 177-р зүйл-4

График №6. Аль эрх зүйн шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хүндрэлтэй байна вэ?



Шийдвэр гүйцэтгэгч нарын 41.1 хувь нь иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг 19.6 хувь нь хорихоос өөр төрлийн ялийг гүйцэтгэхэд, 39.6 хувь нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэлтэй, асуудал үүсдэг гэж тодорхойлсон байна.

Хүндрэл, асуудал үүсдэг шалтгаан нь:

Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт 1.Албадан дуудлага худалдаа явагдах процесс зохицуулалт муу, 2.ШГА-нд гомдол гаргах хугацаа, тоонд хэмжээ тогтоох, 3.Төлбөр төлөгчид үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох зохицуулалт байхгүй; **Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт** 1.Шүүхээс гарч буй шийдвэр ойлгомжгүй, биелүүлэх боломжгүй байдаг, 2.Албан тушаалтнууд шүүхийн шийдвэрийг биелүүлдэггүй; **Хорихоос өөр төрлийн ялыг гүйцэтгэхэд** 1.Ял эдэлж байх хугацаанд тухайн хүний эд хөрөнгөд халдах, 2.Шүүхээс тухайн хүний эд хөрөнгийн нөхцөл бололцооноос өндөр төлбөр ногдуулсан байдаг

График№7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалтгүй байгаа шалтгааныг дор дурьдсан зүйлүүдээс алийг нь гэж үзэж байна вэ?




Шийдвэр гүйцэтгэгч нар шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалтгүй шалтгааныг тодорхойлохдоо:

⁶⁹Нээлттэй асуулга №7

1. ШШГБ бусад хууль сахиулах байгууллагын /Цагдаа/ уялдаа, хамтын ажиллагаа хангалтгүй /74.2 хувь /
2. Хууль эрх зүйн орчин, зохицуулат муу /48.5 хувь/
3. Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын уялдаа холбоо муу /45.5 хувь/ гэж үзсэн байна.

График №8. Шүүхээс гарч буй шийдвэр, магадлал, тогтоолын чанар, хэрэгжих боломж ямар вэ?



Шүүхээс гарч буй шийдвэрийн чанарыг нийт санал асуулгад оролцсон шийдвэр гүйцэтгэгчдийн 94 хувь нь дунд болон муу гэж дүгнэсэн байна.

Хүснэгт №1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараах үе шатуудаас аль хэсгийг өөрчлөх, сайжруулах шаардлагатай байна вэ?

№	Ажиллагаа	Тийм	Үгүй
1	Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх	11.3%	88.7%
2	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдэгдэл, тэмдэглэл	20.8%	79.2%
3	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, үе шат	34.0%	66.0%
4	Эд хөрөнгө худалдан борлуулах ажиллагаа	69.8%	30.2%
5	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох, хязгаарлагдсан эрхийг сэргээх	9.6%	90.4%
6	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах	32.7%	67.3%
7	Төлбөр гаргуулсан мөнгөн хөрөнгийг хуваарилан олгох ажиллагаа	30.8%	69.2%


Хуульд заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шатуудаас хамгийн их маргаантай, өөрчлөн сайжруулах шаардлагатай нь Эд хөрөнгө худалдан борлуулах ажиллагаа (69.8%) байна.

ШШГАжиллагааг сайжруулах талаар таны санал⁷⁰

- ✚ ШГА-ны явц бүрт гомдол гаргадаг. Түүний хэмжээ хязгаартай болгох - 10
- ✚ Эд хөрөнгө худалдан борлуулах ажиллагааг нэг бүрчлэн хуульчлах, журамлах - 7
- ✚ Төлбөр төлөгч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хариуцлагын системтэй болгох - 7

⁷⁰Нээлттэй асуулга №7

✚ Шийдвэр гүйцэтгэгч нарын эрх хэмжээг нэмэгдүүлэх, дээшлүүлэх - 5
 График №9. Хорихоос өөр төрлийн ялын шийдвэрийг биелүүлэхэд аль нь хүндрэлтэй байдаг вэ?




Эрүүгийн шүүхийн шийдвэрээс хорихоос өөр төрлийн 4 төрлийн ялыг шийдвэр гүйцэтгэгч нар гүйцэтгэдэг. Хорихоос өөр төрлийн ялаас торгох ял (59.3%)-ыг гүйцэтгэхэд асуудал бэрхшээл хамгийн ихээр тулгардаг байна. Гүйцэтгэхэд хүндрэлтэй байгаа шалтгаан:⁷¹

- ✚ Шүүхээс төлбөрийн чадваргүй ялтанд өндөр торгууль ноогдуулдаг - 25
- ✚ Ял эдэлж буй хүнээс төлбөр, торгууль гаргуулахад хүндрэлтэй байдаг – 5

Иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдээс эд хөрөнгийн барьцаа 2, хуулийн этгээдээс тайлбар гаргуулах ажиллагаа 4, орон байр албадан чөлөөлөх 1, албадан дуудлага худалдааг гүйцэтгэх 9 зэрэг ажиллагаанууд хүндрэлтэй байдаг бол захиргааны шүүхийн шийдвэрүүдээс ажилд эргүүлэн томилох 30, газрын маргаан 5 зэрэг шийдвэрүүд байдаг байна.

График №10. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлдэггүй, хангадаггүй төрийн албан тушаалтнуудыг сонгоно уу?




⁷¹ Нээлттэй асуулга №14.2

Захиргааны шүүхийн шийдвэрүүдээс ямар шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хүндрэлтэй байдаг вэ?⁷²

- ✚ Ажилд эргүүлэн томилох - 25
- ✚ Газрын маргаан - 5

Судалгаанд оролцсон шийдвэр гүйцэтгэгч нар захиргааны шүүхийн шийдвэрүүдийг биелүүлдэггүй төрийн албан тушаалтанаар: нийслэл, дүүргийн засаг дарга нар 35.4 хувь, Яам, түүний сайд, төрийн нарийн бичгийн дарга 33.3 хувь, нийслэл, дүүргийн алба, хэлтэс 12.5 хувь гэж сонгожээ.

График №11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид үр чадвартай, бүтээлч ажиллахад сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлно уу?



Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид үр нөлөөтэй ажиллахад хамгийн ихээр цалин хөлс бага, нийгмийн асуудал шийдвэрлэгдээгүй байдал 76.2 хувь, мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх боломж хомс 71.4 хувь, хууль эрх зүйн орчин боловсронгуй бус 47.6 хувиар нөлөөлж байна.

⁷²Нээлттэй асуулга №16